

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
2009 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

**Эрүүл мэндийн салбарт:**

Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45, 46.3 дахь заалт, Тэргүүн шадар болон Шадар сайдын 2009 оны 46 дугаар тушаалыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2009 оны 282 дугаар тушаалаар Булган аймагт баригдаж буй спорт цогцолбор, Хөвсгөл аймаг, Хатгал тосгонд хэрэгжиж буй эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх төсөл, Хавдар судлалын үндэсний төвийн дэргэд хорт хавдрын туяа, хими, хөнгөвчлөх эмчилгээ хийлгэж байгаа өвчтөнүүдэд зориулсан Улаанбаатар сувилал байгуулах ажлыг гүйцэтгэх эрхийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцаас Булган аймгийн Засаг дарга, ХӨСҮТөвийн захирал нарт тус тус шилжүүлж, эдгээр арга хэмжээг санхүүжүүлэхийг Төрийн нарийн бичгийн даргад зөвшөөрсөн байна.

Засгийн газрын 2009 оны 239 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан 2009 оны 283/207 дугаар тушаалаар халдварт бус өвчний нийтлэг эрсдэлт хүчин зүйлийг бууруулах *“Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги”*, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тус тус баталж, стратегийг хэрэгжүүлэхэд олон улсын байгууллага, хандивлагчдын зээл, тусламжийн тодорхой хэсгийг чиглүүлэхийг дэд сайд нарт, хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр боловсруулж хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгов.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 12.2 дугаар заалт, Засгийн газрын 2007 оны 92 дугаар тогтоолыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2009 оны 287 дугаар тушаалаар Эрүүл мэндийг дэмжих сангийн ажлын албаны чиг үүргийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газарт шилжүүлж, *“Эрүүл мэндийг дэмжих сангийн ажлын албаны ажиллах журам”*-ыг батлан мөрдүүлэв.

Эх, хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах төсөл, хөтөлбөрүүдийн уялдааг хангах зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2009 оны 289 дүгээр тушаалаар эх, хүүхдийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, үр дүнг нэгтгэн мэдээлж байх үүрэг бүхий ажлын хэсгийг 20 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг хэлэлцэх хуваарийг батлан ажлын хэсгийн хурлаар хэлэлцсэн асуудлыг тухай бүрт нь сайдад танилцуулж, асуудал шийдвэрлүүлэх, зайлшгүй шаардлагатай тохиолдолд Эрүүл мэндийн салбар дахь зээл, тусламжийг зохицуулах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж байхыг ажлын хэсгийн ахлагчид даалгав.

Нийслэлийн II амаржих газарт их засвар хийгдэж байгаатай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2009 оны 291 дүгээр тушаалаар Эх нялхсын эрдэм шинжилгээний төвд Сонгинохайрхан дүүргийн 1-8, 20-25 дугаар хорооны, “Номун” хувийн хэвшлийн эмнэлэгт тус дүүргийн 9-19 дүгээр хорооны харьяаллын жирэмсэн эмэгтэйчүүдэд эх барихын яаралтай тусламжийг 2009 оны 9 дүгээр сарын 10-наас 11 дүгээр сарын 02-ны өдрийг хүртэл үзүүлэхээр шийдвэрлэж энэ хугацаанд нийслэлийн II амаржих газрын засвар, ариутгал, халдваргүйтгэлийг чанартай хийж дуусгах, дээрхи эмнэлгүүдийн тусламж үйлчилгээнд нэмэлтээр шаардагдах санхүүжилт, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хуваарилан ажиллуулахыг холбогдох албан тушаалтнуудад даалгав.

Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2009 оны 293 дугаар тушаалаар *“Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах стратеги”*, хог хаягдлын менежментийг сайжруулах үйл ажиллагааны 2009-2013 оны төлөвлөгөөг тус тус баталж, хэрэгжилтийг зохицуулан хяналт тавьж, хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улс, орон нутгийн төсөвт тусган шийдвэрлүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад даалгав.

Эрүүл мэндийн тухай хуулийн 26<sup>1</sup> дугаар зүйлийн 1.3 дэх заалт, Санхүү, эдийн засгийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2001 оны хамтарсан 26/38 дугаар тушаалын 3.1 дэх заалтыг тус

тус үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2009 оны 297 дугаар тушаалаар төрийн зардлаар төгсөлтийн дараах сургалтад орон нутгаас суралцагсдын хяналтын тоог 563-аар, тэдгээрийн сургалтын зардлыг 292.5 сая төгрөгөөр, бусад сургалтын зардлыг 72,8 сая төгрөгөөр тус тус тогтоов.

ДЭМБ-ын “Хөгжиж буй орнуудад зайлсхийж болох дүлийрэлт, сонсгол бууралтыг багасгах хамтын ажиллагааны хөтөлбөр”, Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2009 оны 303/126 дугаар тушаалаар “Дүлийрэлт, сонсгол бууралтаас сэргийлэх, хянах үндэсний стратеги”, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тус тус баталж, стратегийг хэрэгжүүлэхэд олон улсын байгууллага, хандивлагчдын зээл, тусламжийн тодорхой хэсгийг чиглүүлэх, шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг холбогдох албан тушаалтнуудад даалгав.

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 17.5 дугаар заалт, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн 2009 оны 8 дугаар сар 28-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2009 оны 305 дугаар тушаалаар гадаадын 24 эмнэлгийн мэргэжилтэнд Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгохоор шийдвэрлэв!

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, үйлчлүүлэгчийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах үйл ажиллагааг дэмжих зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2009 оны 307 дугаар тушаалаар эмнэлгийн тусламж үйлчилгээний шатлал, шатлал хооронд үйлчлүүлэгч шилжүүлэх тогтолцооны загварыг тус тус баталж, энэхүү тушаалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг орон нутаг, байгууллагын нөөц бололцоог ашиглан шийдвэрлэж, хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгов.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2009 оны 308/189/129 тоот хамтарсан тушаалаар гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээний төвийг ЭМЯ-ны харьяа Гэмтэл согог судлалын үндэсний төв, ХЗДХЯ-ны харьяа Шүүх эмнэлэг, нийслэлийн ЭМГ-ын харьяа Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн нэгдэл дээр тус тус байгуулж, хохирогчид үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээний журам, нэг цэгийн үйлчилгээний үйл ажиллагааг уялдуулж зохицуулах орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг тус тус баталж, нэг цэгийн үйлчилгээг 2009 оны 9 дүгээр сард багтаан эхлүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад даалгав.

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны наймдугаар сар 18-ны өдрийн тогтоолоор Хавдар судлалын Үндэсний төвийг Монгол Улсын Хүний гавъяат эмч, доктор, профессор Н.Нямдаваагийн нэрэмжит болгох шийдвэрийн дагуу ХСҮТ-ийн шинэ хаягийг хадаж, Хүний гавъяат эмч Н.Нямдаваагийн дурсгалын хөшөөг нээх ёслол 2009 оны есдүгээр сар 9-ний өдөр боллоо.

ДОХ, сүрьеэ, хумхаа өвчинтэй тэмцэх Глобаль сангийн Зүүн Ази, Номхон далайн баруун бүсийн ҮИ хурал 2009 оны есдүгээр сарын 3-ны өдөр Улаанбаатарт болов. Бүс нутгийн орнуудад Глобаль сангаас хоёр жил тутамд зохион байгуулдаг энэ удаагийн хурлаар Глобаль сангийн үйл ажиллагааны талаар шинэлэг мэдээлэл өгч, тус сангийн санхүүжилтээр төсөл хэрэгжүүлж байгаа улс орнуудын туршлагыг сонсч, харилцан санал бодлоо солилцохын зэрэгцээ, тулгарч буй саад бэрхшээлийг шийдвэрлэх арга замын талаар ярилцаж, Глобаль сангийн Үндэсний зохицуулах зөвлөлийг бэхжүүлэх, түүний хяналт явуулах чадавхийг сайжруулах талаар танилцуулав.

#### **Боловсролын салбарт:**

**Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол:** Сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаанд мөрдөгдөх эрх зүйн зарим акт, тухайлбал, *бага насны хүүхдийн хөгжлийн стандартын* төслийг эцэслэн боловсруулсны дээр “Хүүхдийн хоол бэлтгэх зөвлөмж” гарын

авлагыг боловсруулж, хэвлүүлэв. Мөн бага насны хүүхдийг хөгжүүлэх хувилбарт сургалтын хөтөлбөрийн хүүхдэд зориулсан дасгал ажлын дэвтрийг боловсруулж хэвлэлтэд шилжүүлээд байна.

2009 онд шинээр хэвлэсэн ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн хоёрдугаар ангид хэрэглэх 5 сурах бичгийг яамны ВЭБ сайтад байршуулснаар багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн оюутан, суралцагч, бага ангийн багш нар төдийгүй хилийн чандад үйл ажиллагаа явуулж байгаа Монгол сургуулиуд эдгээр сурах бичгийг сургалтад хэрэглэх боломж бүрдэж байна.

2009-2010 оны хичээлийн жилийн элсэлт, сурах бичиг хангамж, нийлүүлэлтийн асуудлаар 2 удаа хэвлэлийн бага хурал зохион байгуулж, энэ хичээлийн жилийн онцлог, ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын тоо, сурах бичгийн хүргэлтийн явц, багшийн хүрэлцээ, хангамж зэрэг асуудлаар тодорхой мэдээллийг иргэд, олон нийтэд өглөө.

*“Баян-Өлгий аймгийн боловсролын салбарын өнөөгийн нөхцөл байдал, тулгарч буй асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох судалгаа”-ны ажлын үр дүнг аймгаас Улсын Их Хуралд сонгогдсон гишүүд, аймгийн Засаг дарга, багш, иргэдийн төлөөлөлд танилцуулах уулзалт-хэлэлцүүлгийг зохион байгуулж, цаашид тус аймгийн боловсролын байгууллагын ажлын үр нөлөөг дээшлүүлэх, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, багш нарыг давтан бэлтгэх, тэднийг чадваржуулах асуудлаар хамтран ажиллах ажлын чиглэлээ тодорхойлов.*

“Санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2009 оны 22 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Нэн тэргүүнд боловсруулж, батлуулах шаардлагатай хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн жагсаалт”-ын 19 дүгээрт заасны дагуу “Санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах боловсролын салбарын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн төсөл болон “**Боловсрол**” үндэсний хөтөлбөрийн төслийг эцэслэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанд оруулахад бэлэн болгоолоо.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран АББ-ын үндэсний сургагч багш бэлтгэх “*Бизнестэй танилц*” сургалтын бэлтгэл ажлыг хангаж, 2009 оны 09 дүгээр сарын 07-17-ны өдрүүдэд энэхүү сургалтыг зохион байгуулав. Сургалтад 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн албан бус боловсролын багш нарыг хамруулж, сургалтын багц материалаар хангав. Бэлтгэгдсэн сургагч багш нар орон нутагтаа сургууль завсардсан, ажил мэргэжилгүй 1000 хүүхэд, залуусыг бизнесийн соёлд сургах бөгөөд цаашдаа АББ-ын “*Тэгээрэл*” төвөөр дамжуулан бизнесийн сургалтыг байнга явуулах боломж бүрдэж байгаа юм.

Бага, суурь, боловсролын дүйцсэн сургалтын Хэл-Эх дэлхий (бүрэн дунд), Бидний эргэн тойронд (бүрэн дунд), Бодис бидний амьдралд (бүрэн дунд), Технологи (бүрэн дунд), Байгалийн гамшиг (бүрэн дунд) 5 модулийг зохиогч нартай хамтран боловсруулж, редакторын засварыг хийж, хэвлэлийн эхийг бэлтгэв. Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “*Малчдын хүүхэд, залууст зориулсан зайны сургалт*”, “*Бичиг үсгийн боловсрол олгох*” төслийн хүрээнд “*Амьдралын их сургууль*” сонины 9 дэх дугаарыг боловсруулан 7500 хувь хэвлэж, төсөлд хамрагдсан аймгуудад хүргүүлээд байна.

Сургуулийн номын сангаар олгох сурах бичгийг нэн түрүүнд бүтэн өнчин, эцэг эх нь хөгжлийн бэрхшээлтэй, группэд байдаг, төрийн өмчийн сургуульд 3 хүүхэд нь зэрэг суралцдаг өрхийн хүүхдэд олгох шаардлагатай гэж тус яам үзэж байгаа бөгөөд энэ талаар дэлгэрэнгүй зөвлөмж боловсруулан аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газрын дарга, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт хүргүүлэх арга хэмжээ авсны дээр 2009-2010 оны хичээлийн жилд ашиглах ерөнхий боловсролын сургуулийн журналыг хэвлүүлэх ажлыг зохион байгуулж, түүнийг түгээх, татан авах явцад хяналт тавьж ажиллалаа.

**Дээд болон мэргэжлийн боловсрол:** Монгол Улсын бакалаврын боловсролын 20 стандартын төсөл боловсруулан Стандартчилал, хэмжил зүйн газрын салбарын дэд хорооны 2009.09.25-ны өдрийн хуралдаанаар 18-ыг нь дэмжүүлсэн.

Дээд боловсролын шинэчлэлийг гүнзгийрүүлэх, сургалтын түвшинг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор “Дээд боловсролын шинэчлэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, “Дээд боловсролын шинэчлэлийг дэмжих хөтөлбөр /2009-2012/” –ийн төслийг боловсруулав.

БСШУ-ы сайдын 2009 оны 381 дүгээр тушаалаар *Мэргэжлийн боловсрол, сургалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг* тогтоов.

Сургалтын төрийн сангийн зээлээр БНУУ, БНПУ-ын их, дээд сургуульд суралцах 15 оюутанд амьжиргааны тэтгэлэг олгох, Польшид суралцах Монголын оюутнуудын “Тэтгэлгийн хөтөлбөр”-ийн хүрээнд 10 оюутныг суралцуулах асуудлыг БСШУ-ы сайдын тушаалаар шийдвэрлэв.

“Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын дэд хөтөлбөр”-ийг боловсруулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдаар баталгаажуулан “Оюутны хөдөлмөр эрхлэлтийн төв”-ийг Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Санхүү, эдийн засгийн дээд сургууль, Нийслэлийн хөдөлмөрийн газрын дэргэд байгуулан байнгын ажиллагаатай болгосон нь ач холбогдлоо өгч байна.

2009-2010 оны хичээлийн жилийн статистик мэдээ нэгтгэн гарахтай холбогдуулан 2008-2009 оны хичээлийн жилийн 154 дээд боловсролын байгууллагын ангилал, нэр, статуст дүн шинжилгээ хийж, одоогийн байдлаар дээд боловсролын сургалтын 148 байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа урьдчилсан мэдээг гаргаад байна. Мөн яаралтай статусын асуудлыг шийдэх шаардлагатай 3-4 сургууль байна.

**Соёл, урлаг:** Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлалын анхны хувилбарыг боловсруулсны дээр “Монголын биет бус соёлын өвийг хамгаалж дэмжих асуудалд” симпозиум, “Монгол Улсад ЮНЕСКО-гийн “Хүн-амьд эрдэнэ” хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь” сургалт, семинарыг Биет бус соёлын өвийн Ази-Номхон далайн бүсийн төв, БНСУ-ын Соёлын өвийн захиргаа, Соёлын өвийн сан, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисстой хамтран зохион байгууллаа.

“Ерөнхий боловсролын сургууль, нийтийн номын санд тэргүүн ээлжинд байвал зохих номын жагсаалт”-аар батлагдсан 198 нэрийн 200000 гаруй ширхэг ном /1,7 тэрбум төгрөгийн өртөг бүхий/-ыг Хүүхдийн номын ордонд хүлээн авч төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, аймаг, сум, сургуулиар нь хуваарилан түгээх ажлыг зохион байгууллаа. Сумын болон ерөнхий боловсролын сургууль, МСҮТ-ийн номын санг баяжуулах зорилгоор 5 нэрийн 140.0 сая төгрөгийн номыг тэдгээрт нийлүүлэх асуудлыг “Номын хангалт хийх тухай” БСШУ-ы сайдын тушаалаар шийдвэрлэж, Азийн сантай хамтран төрийн өмчийн 44 их, дээд сургуульд 30,000 нэрийн номыг хандивлахаар тохиролцов. Мөн Германы ЭСЯ, Гёте институттэй хамтран “Ном сэлбэн засварлах” сургалт, олон улсын номын сангийн нээлттэй программ хангамж “КОХА” программыг эзэмшүүлэх 3 хоногийн сургалтыг тус тус зохион байгуулж, эдгээр сургалтад 130 орчим номыг санчийг хамруулсан нь хуучирсан номыг сэргээн засварлаж ашиглах, номын сангийн үйлчилгээнд цахим үйлчилгээ нэвтрүүлэхэд тус нэмэр болох арга хэмжээ болов.

**Шинжлэх ухаан, технологи.** Инновацийн тухай хуулийн төслийн эцсийн хувилбарыг боловсруулж дуусган холбогдох байгууллага, мэргэжлийн хүмүүсийн санал авахад бэлэн болгоод байна. Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журмын дагуу салбарын яамдаас ирүүлсэн 83 төслийн захиалгын саналыг дээр дурдсан журамд нийцүүлэн ШУА-ийн холбогдох Бага чуулгануудаар үнэлгээ, дүгнэлт гаргуулж, дэмжигдсэн төслүүдийг БСШУ-ы сайдын 2009 оны 379 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг эцэслэн шүүлт хийж, 22 төслийг 2010 оноос эхлэн хэрэгжүүлэхээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлахад бэлтгээд байна.

Загас үржүүлгийн эрдэм шинжилгээний төв байгуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлсний зэрэгцээ Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийн хоёр дахь хувилбарыг боловсруулан эрдэмтэн, мэргэжилтнээр хэлэлцүүлэх, хөндлөнгийн экспертизад шилжүүлэх бэлтгэлийг хангалаа.

БНСУ-аас хэрэгжүүлж байгаа “Зүүн Азийн бүс нутгийн цаг уурын өөрчлөлтийн нөхцөлд хамтран ажиллах хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх судалгаа, боловсруулалтын 17 төслийн саналыг бэлтгэн Сангийн яаманд хүргүүлэв.

Монгол судлалын 50 жилийн ойн арга хэмжээний хүрээнд монголч эрдэмтдийн олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж АНУ, Япон, БНХАУ, ОХУ, Солонгос зэрэг улсын монголч эрдэмтэн, судлаачдыг оролцуулав.

**Санхүү, хөрөнгө оруулалт:** Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын 2010 оны төсвийн төслийг Сангийн сайдтай 487,9 тэрбум төгрөгөөр эцэслэн тохирсон болно. Энэхүү дүн нь энэ оны батлагдсан төсвийн лимитээс 9,4 тэрбум төгрөгөөр, 2009 оны тодотгосон төсвөөс 45,9 тэрбум төгрөгөөр илүү байна. Төсвийн төсөлд туссан нийт дүнгийн 434,3 тэрбум төгрөгийг урсгал зардал, 53,7 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын зардал эзэлж байна.

Боловсролын төвлөрсөн арга хэмжээний зардлаас гамшигт өртсөн аймгуудийн сургууль, цэцэрлэгийн засварт зориулан 243.3 сая төгрөгийн санхүүжилт хийсний дээр их, дээд сургуулиудын 3 дугаар улирлын тогтмол зардлын санхүүжилтийг олгов. 2009 оны эхний 9 сарын байдлаар төрийн өмчийн 24 их, дээд сургуульд 2338.0 сая төгрөгийн санхүүжилт олгоод байна. Мөн Монгол Улсад зохион байгуулсан ОХУ-ын Соёлын өдрүүдийн арга хэмжээг 105.4 сая төгрөгөөр санхүүжүүлэв.

Япон Улсын Засгийн газрын төслийн бус буцалтгүй тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх 27 нэр төрлийн гарын авлагыг хэвлэх, нийлүүлэх тендерийн баримт бичгийг боловсруулах ажил хийгдэж байна.

2009-2010 оны хичээлийн жилд 6 настай хүүхдэд хичээл заах багш болон тэдэнтэй ажиллах нийгмийн ажилтны мэргэшил дээшлүүлэх сургалтын санхүүгийн тайланг гаргав. Энэхүү сургалтад зориулж Үр дүнд түргэн хүргэх санаачилгын төслөөс 374.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд үүний 302.4 сая төгрөгийг зарцуулж 72.0 сая төгрөгийг хэмнэлээ. Нийт хэмнэлтийн 85 хувь буюу 61.5 сая төгрөг хөдөө орон нутагт хийх сургалтын замын зардал, томилолтын зардлаас хэмнэгдсэн байна. Сургагч багш-82, багш, нийгмийн ажилтан 1607-г энэхүү сургалтад оролцуулав. Харин замын зардлыг улсын тарифаар биш ирсэн нь үнэн гэсэн өндөр тарифаар хийж байх нь зүйтэй байх гэсэн саналыг тавьж байсан нь санхүүжүүлэх боломжгүй зүйл байлаа.

Энэ оны 9 дүгээр сарын 23-ны өдөр Сангийн яамнаас зохион байгуулсан “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн дахин үнэлгээ” сургалтад салбарын төсвийн ерөнхийлэн захирагчийн харъяа байгууллагуудын 400 гаруй нягтлан бодогчийг оролцуулан хөрөнгийн дахин үнэлгээг энэ онд багтаан хийж үр дүнг санхүүгийн тайланд тусгах талаар даалгавар өглөө.

Азийн хөгжлийн банкны “Боловсролын хөгжлийн хөтөлбөр-3”-ийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн багш нарт зориулсан хичээлийн агуулгын 2 хоногийн сургалтыг цахим программаар зохион байгуулж, түүнд аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газрын мэдээлэл зүйн арга зүйчид, ерөнхий боловсролын сургуулийн мэдээлэл зүйн багш нараас 51 хүнийг оролцуулав.

Боловсролын салбарын барилга, их засварын данснаас энэ 9 сард нийт 71 гүйлгээгээр 3,298,9 сая төгрөгийн 21 барилга угсралт, 16 их засвар, тоног төхөөрөмж нийлүүлэх 3 ажлын гүйцэтгэлийг хянаж, шаардлагатай санхүүжилтийг олгон барилга угсралтын ажлыг хурдасгаад байна.

Боловсролын салбарт 2009 оны 9 дүгээр сард 3 барилга (1240 хүүхдийн суудал бүхий хүчин чадалтай 2 хичээлийн барилга / Хэнтий аймгийн Өндөрхаан, Өмнөдэлгэр/, 100 хүүхдийн ортой 1 цэцэрлэгийн барилга / Архангайн Эрдэнэбулган/), 13 их засварын ажлыг дуусган ашиглалтад хүлээн авлаа.

2009-2010 оны хичээлийн жилийн эхний байдлаар улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургуульд 510,3 мянган хүүхэд хичээллэж байна. Үүнээс нэгдүгээр ангид 50,0 мянган хүүхэд, аравдугаар ангид 34,5 мянган хүүхэд суралцаж байна. Цэцэрлэгт 99,1 мянган хүүхэд хүмүүжиж байна.

БНСУ-ын Соёлын өвийн захиргааны төлөөлөгчид БСШУЯ болон тус байгууллагын хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу Монгол Улсад 2009 оны 9 дүгээр сарын 22-27-ны өдрүүдэд хийсэн албан ёсны айлчлалыг зохион байгуулж, санамж бичгийн дагуу авах арга хэмжээний төлөвлөгөөг сунгах талаар харилцан тохиролцов.

#### **Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн чиглэлээр:**

Засгийн газрын 2009,04,13-ны өдрийн хуралдаанаас өгсөн үүргийн дагуу Монгол-Хятадын ажиллах хүчний талаар хамтран ажиллах тухай хэлэлцээр байгуулах ажлыг зохион байгуулж 2009.09. 17-18-ны өдрүүдэд мэргэжилтнүүдийн түвшний 2 дахь удаагийн хэлэлцээг Улаанбаатар хотод хийв.

Монголын Улсын Засгийн газар болон БНХАУ-ын “Үндэсний цахилгаан сүлжээ” корпорацийн хооронд *Шивээ-Овоогийн нүүрсний уурхай-дулааны цахилгаан станцын цогцолбор* барих төслийн хөрөнгө оруулалтын ерөнхий гэрээнд ажиллах хүчний асуудлаар тусгах саналаа Засгийн газрын ажлын хэсэгт хүргүүлсний дээр уг асуудлаарх дэд ажлын хэсгийг НХХ-ийн сайдын 2009.09.14-ний өдрийн 120 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлалыг Засгийн газар, нийгмийн түншүүд болох МАОЭНХ, МҮЭХ-ны төлөөлөл бүхий ажлын хэсэг боловсруулж дууссан бөгөөд хуулийн үзэл баримтлалыг Хууль зүй дотоод хэргийн яамаар батлуулж, МАОЭНХ, МҮЭХ болон холбогдох яамдаас санал авч байна.

“Нийгмийн халамжийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөлд яамдаас ирүүлсэн саналыг тусган боловсруулж Засгийн газарт оруулахад бэлэн болгов.

Нийгмийн халамжийн тэтгэмж, үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэх зорилгоор ядуу өрх иргэний амьжиргааны түвшинг тогтоохоор АХБ-аас санал болгосон “*Орлогыг орлуулан тооцох аргачлал*” (ООТА)-ын монгол хувилбар боловсруулах ажлын хэсгийн уулзалт, ярилцлагыг зохион байгуулав.

НХХ болон ЭМ-ийн сайдын 2009.08.21-ний өдрийн 114/269 тоот хамтарсан тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг “Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын эхний төслийг боловсруулан сайдын зөвлөлийн хуралд оруулахаар бэлтгэв.

Зүүн хойд азийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын дэд бүсийн 4 дүгээр чуулга уулзалтыг Улаанбаатар хотноо амжилттай зохион байгууллаа. Чуулганд Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагын төлөөллүүд болон Солонгос, Япон, Хятад, түүнчлэн Олон Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагын төлөөлөл, нийт 80 гаруй хүн оролцов. Чуулга уулзалтаар 2006 онд НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 61 дүгээр чуулганаар баталсан “*Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци*”, түүний нэмэлт протоколд нэгдэн орох, нэгдэн орсон орнууд конвенцийн хэрэгжилтийг хангах талаар зөвлөлдөж, чуулганаас зүүн бүсийн орнуудаас цаашид анхаарч ажиллах асуудлаар “*Улаанбаатарын тунхаг*” бичгийг гаргалаа.

“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор “Нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах тухай” ЭМ, ХЗДХ, НХХ-ийн сайдын 2009.09.22-ны 308/189/129 тоот хамтарсан тушаал батлагдлаа. Энэ тушаалын дагуу гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээний төв Шүүх эмнэлэг, Гэмтэл согог үндэсний төв болон Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн нэгдэл дээр байгуулагдана.

НҮБ-ын Хүүхдийн сан болон Олон улсын шилжин суурьшлын байгууллагын дэмжлэгтэйгээр БСШУЯ, “Нийгмийн ажлын багш, сурагчдын холбоо”-той хамтран хүүхэд хамгаалал, түүний дотор хүүхдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах, дамжуулан худалдаалахтай тэмцэх асуудлаар нийгмийн ажилтныг чадавхижуулах сургалтыг гурван үе шаттайгаар зохион байгуулж байна. Гуравдугаар шатны хүрээнд “*Хүүхэд хамгааллын асуудал болон хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх нь*” сэдвээр 2009.09.16-19-ний өдрүүдэд “*Сургагч багш*” бэлтгэх сургалтыг зохион байгуулсан. 2009 онд 8 аймагт сургалт зохион

байгуулахаар төлөвлөснөөс 9 дүгээр сард Увс, Хөвсгөл, Өвөрхангай, Баянхонгор аймгуудад зохион байгууллаа.

“Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, стандарт”-ыг олон улсын стандартчилсан ангилалтай нийцүүлэн шинэчлэх ажлыг үргэлжлүүлж, яамдын саналыг хүлээн авч байна. “ISCO-08” олон улсын стандартчилсан ангиллыг орчуулах, хэвлэхэд шаардагдах зардлыг олгох хүсэлтийг ОУХБ-ын Бээжингийн товчоонд хүргүүлж 8,4 мянган ам. доллар шийдвэрлүүлснээр “ISCO-08”-ийг орчуулах, Үндэсний ангилал, тодорхойлолтыг шинэчлэх ажил нэгэн зэрэг үргэлжлэн явагдаж байна.

“Алслагдсан болон говийн бүсийн нэмэгдэл олгох оновчтой хэлбэрийг бий болгох” зорилтыг хэрэгжүүлэх, бүс нутаг, зорилтот бүлгүүдийг судалж тодорхойлох судалгааны ажил 8 дугаар сараас эхэлсэн бөгөөд төслийн агуулгад нийцүүлэн 18,0 сая төгрөгийн өртөг бүхий төсөл хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, судалгааг энэ онд багтаан гүйцэтгүүлэхээр “Мал, тариалангийн эрсдлийг судлах төв” ТББ-тай гэрээ байгуулав. Энэ төсөл нь говийн бүсийн нэмэгдэл олгох шаардлага байгаа эсэх, нэмэгдлийн оновчтой хэлбэрийн талаарх бодлогын үндэслэлийг тодорхойлоход чиглэж байгаа юм.

Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт 2007-2008 оны улсын хэлэлцээрийг 2009.09.04-нд талууд дүгнэж гэрээнд тусгагдсан 43 асуудал 81,3 хувийн биелэлтэй байна гэж үзэв.

Хөдөлмөр нийгмийн зөвшлийн Үндэсний хорооны хурлыг 2009.09.08-нд хийж, Сангийн яам, Нийгмийн хөгжил, шинэтгэлийн хорооноос 2010 оны үндсэн чиглэл, 2010 оны улсын төслийн төслийн асуудлаар, НХХЯ-наас Нийгмийн халамжийн хуулийн шинэчлэлийн асуудлаар тус тус мэдээлэл хийсэн.

НХХ-ийн сайдын 2009 оны 124 дүгээр тушаалаар “Эмнэлгийн хуудас олгох журам”-ыг батлуулж яамны вэб хуудсанд байршуулав.

2009 оны эхний 9 сард Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдэд бүртгүүлсэн ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 40.3 мянга болж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ажилгүй иргэдийн тоо 8969 хүнээр буюу 28.6 пунктээр, ажилгүйдлийн түвшин 3.7 хувь болж 0.7 пунктээр тус тус нэмэгдсэн байна.

Тайлангийн хугацаанд ажил олгогчдоос нийт 41270 ажлын байрны захиалга ирүүлсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тайлант хугацаанд ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны захиалга 3499-өөр буюу 9.3 пунктээр нэмэгдсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд Засгийн газрын 2006 оны 166 дугаар тогтоолоор батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох зээлийн хүү нөхөн төлөх журам”-ын дагуу банк, банк бус санхүүгийн байгууллагуудаар дамжуулан жижиг зээл олгож байна. 2009 оны эхний 9 сарын байдлаар Хас, Монгол Шуудан, Капитал, ХААН банкууд, Актив Инвест, Ажилгүйдлийг Бууруулахад Туслах сан, Капмон, Ситихөгжил, Арвис Итгэл, Цэцэрлэг-Ар, Үнэнч-Итгэл, Ситизенс, Цэнуж банк бус санхүүгийн байгууллагуудаар дамжуулан 1467 албан бус хөдөлмөр эрхлэгч, 1938 ажилгүй иргэн, 706 малчин, 172 аж ахуйн нэгж, байгууллагад 6 тэрбум 681.8 сая төгрөгийн зээлийг олгосноор 9757 хүн ажлын байраар хангагдсан байна.

Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээ: 2009 оны эхний 9 сарын байдлаар Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт үйлчилгээнд нийт 1425.0 мянган хүн хамрагдаж тэдэнд 169.247.623,0 мянган төгрөг зарцуулсан байна.

Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. дахь хэсэг, Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн дагуу 0-18 хүртэлх насны хүүхэд бүрт олгох 100.0 мянган төгрөгийг тухайн хүүхдийн нэр дээр нээсэн банкин дахь мөнгөн хадгаламжийн дансаар дамжуулан улирал бүр тэнцүү хуваарилан олгож байгаа бөгөөд 2009 оны эхний 9 сард нийт **929011** хүүхдэд **66047169.0** мянган төгрөг олгосон байна.

**Үндэсний хөгжил, шинэтгэлийн чиглэлээр:**

Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2010-2015 оны тэргүүлэх чиглэлүүдийг 2004-2009 оны эдийн засаг, нийгмийн хөгжилд хийсэн дүн шинжилгээ, Мянганы хөгжлийн зорилтуудад суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын 2010-2021 оны стратегийн зорилтууд, эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэх цаг үеийн шаардлагад нийцүүлэн боловсруулсан.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2010-2015 оны тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл боловсруулж, 2010 оны эдийн засгийн бодит өсөлт 7.4 хувь байхаар тооцож гаргасны үндсэн дээр Засгийн газрын 2009.09.30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн мэдүүлэхэд бэлэн болгосон.

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтын 3 дахь илтгэлийг бэлтгэж Засгийн газрын 2009.09.30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн мэдүүлэхэд бэлэн болгосон.

Инновацийн тухай хуулийн төсөл болон хуулийн үзэл баримтлалыг боловсруулсан.

Хөгжлийн төлөвлөлт, эдийн засгийн удирдлага, зохицуулалтын тухай хуулийн төсөл, хуулийн үзэл баримтлалыг боловсрууллаа.

Гадаад орон болон үндэсний хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор бүтээн байгуулалтад чиглэсэн 200.0 сая. ам доллараас багагүй хөрөнгө шаардагдах бүтээн байгуулалтын төслүүдийг 2009 онд багтаан олон нийтэд зарлах тухай Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.12-д заасныг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Тэргүүлэх ач холбогдол бүхий бүтээн байгуулалтын 15 төслийн баримт бичиг”-ийг боловсруулан Засгийн газрын 2009.09.23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн гарсан саналын дагуу дахин бэлтгэж байна.

Хөгжлийн банк байгуулах тухай асуудлыг Засгийн газрын 2009.09.23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсэн.

Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн бодлогын нэгжийн ажилтнуудад зориулсан “Орон нутгийн хөгжлийн төлөвлөлтийн арга зүй” сэдэвт сургалт, семинар 2009.09.25-26-ны өдрүүдэд зохион байгуулав.

Монгол Улсын 2010-2015 оны томоохон бүтээн байгуулалтын төслүүдийн бүс нутгийн зураглалыг хийж гүйцэтгэв.

#### **Санхүү, төсвийн талаар:**

Жижиг, дунд үйлдвэрийн санхүүжилтийн тухай Засгийн газрын (2009.09.02) хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газрын хуралдаанаас жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зориулалтаар Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуульд тусгагдсан 30.0 тэрбум төгрөгийг Засгийн газрын 2009 оны 178 дугаар тогтоолоор баталсан “**Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл**”-ийн дагуу орон нутгийн түүхий эд, нөөц боломжид тулгуурласан үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх, улс, орон нутгийн чанартай үйлдвэрүүдийг байгуулах, өргөжүүлэх арга хэмжээнд тэргүүн ээлжинд зарцуулах талаар анхаарах; жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгохоос гадна тэдний үйл ажиллагаанд санхүүгийн бусад хэлбэрийн дэмжлэг үзүүлэх талаар тодорхой арга хэмжээ авахыг Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд нарт даалгасан байна.

Газрын тосны бүтээгдэхүүний онцгой албан татварын тухай Засгийн газрын (2009.09.09) хуралдаанаар хэлэлцэж, газрын тосны бүтээгдэхүүний онцгой албан татварын хэмжээг 2009.09.15-ны өдрөөс шинэчлэн тогтоохоор болсон байна.

Вексель гаргах тухай Засгийн газрын (2009.09.09) хуралдаанаар хэлэлцэж, өөрийн хөрөнгөөр барьсан Улаанбаатараас Лүн чиглэлийн 106.2 км авто зам, Лүнгээс Бүст уулын чиглэлийн 62.1 км авто замын гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд санхүүжилт олгох бусад хэлбэрийг дахин судлан саналаа Засгийн газарт танилцуулахыг Сангийн сайдад даалгасан байна. Үүний дагуу Засгийн газрын үнэт цаас гаргах тухай Засгийн газрын (2009.09.23) хуралдаанаар хэлэлцэж, дээр дурдсан авто замын ажлыг санхүүжүүлэх зорилгоор нийт 12,015.7



сая төгрөгийн Засгийн газрын үнэт цаас гаргах тухай асуудлыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр тогтсон байна.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын (2009.09.16) хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газрын 2009 оны 284 дүгээр тогтоолыг баталсан байна.

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын (2009.09.16) хуралдаанаар хэлэлцэж, “2009 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай” Засгийн газрын 2009 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 59 дүгээр тогтоолын хавсралтыг “В.Уул уурхай, олборлолт” гэсэн дэд салбарыг “Түүхий газрын тос, байгалийн хийн хайгуул, олборлолт”, “Уул уурхайн хайгуул, олборлолт, бусад туслах үйл ажиллагаа” гэж; “Г.Барилга” гэсэн салбарын дэд салбарыг “Барилга угсралт”, “Төмөр зам болон авто замын байгууламж барих үйл ажиллагаа”, “Уул уурхайн барилга угсралт” гэж тус тус өөрчилж, нийт ажиллагчдын тоонд эзлэх гадаадын ажиллах хүч, мэргэжилтний хувийг шинэчлэн тогтоосон байна.

Журам батлах тухай Засгийн газрын (2009.09.16) хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газрын 2009 оны 287 дугаар тогтоолоор “Уул уурхай, дэд бүтцийн салбарт алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох журам”-ыг баталж, 2010 оны 1 дүгээр сарын нэгнээс мөрдүүлэхээр тогтоосон байна.

Жагсаалтад нэмэлт оруулах тухай Засгийн газрын (2009.09.16) хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газрын 2009 оны 288 дугаар тогтоолоор Засгийн газрын 2008 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 83 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалт”-д “В.Уул уурхай, олборлолт” гэсэн хэсгийг нэмсэн байна.

Зээлийн хөрөнгийн хуваарилалтын тухай Засгийн газрын (2009.09.16) хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газрын 2009 оны 289 дүгээр тогтоол баталсан байна. Энэ тогтоолоор БНХАУ-ын Засгийн газрын 300.0 сая ам.долларын экспортын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөс барилгын материалын үйлдвэрлэлд зарцуулахаар төлөвлөж байсан 60.0 сая ам.долларыг “Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд 2152 айлын сууц, олон нийтийн барилга байгууламж, сургалт, үйлдвэрлэлийн төвийн хамт барих ажлыг санхүүжүүлэхээр тотоосон байна.

Ажлын хэсгийн саналын тухай Засгийн газрын (2009.09.23) хуралдаанаар хэлэлцэж, эмнэлгийн түргэн тусламж, гал команд, цагдаагийн байгууллагаас бусад байгууллагын тээвэр, шатахууны зардлыг 30 хувиар, төсвийн байгууллагын эд хогшил худалдан авах зардлыг 10 хувиар бууруулах саналыг зарчмын хувьд дэмжиж, Монгол Улсын 2010 оны төсвийн төсөлд тусгахыг Сангийн сайдад даалгасан байна.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2010 онд баримтлах Үндсэн чиглэлийн төслийн тухай Засгийн газрын (2009.09.23) хуралдаанаар хэлэлцэж, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2010 онд баримтлах үндсэн чиглэлд Засгийн газрын гишүүдийн саналыг тусган Монголбанкинд уламжлах нь зүйтэй гэж үзсэн байна.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг Засгийн газрын (2009.09.23, 2009.09.30) хуралдаанаар хэлэлцэж, ирэх оны үндсэн чиглэлийн төсөл болон 2011-2012 оны хандлагын төсөөллийг УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон байна. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд бодит эдийн засгийн салбарыг дэмжиж үйлдвэрлэлийг өсгөх замаар дараахь гол арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна:

- **Эдийн засгийн бодит өсөлтийг 7.4 хувьд хүргэх, инфляцийг 8 хувьд барих, валютын ханшийг тогтвортой байлгах аргаар тооцсон байна. Үүнтэй уялдуулан санхүү, эдийн засгийн хүндрэл, бэрхшээлийг даван туулахын үүднээс эдийн засгийн өсөлтийг дэмжих, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, томоохон хөрөнгө оруулалтын төслийг цогцолбор байдлаар эхлүүлэхээр тусгаж, төсвийн орлогын бааз суурийг өргөтгөх, бүртгэл тооцоо мэдээллийн тогтолцоог сайжруулан төсөвт төвлөрөх орлогыг нэмэгдүүлэх, төсвийн тогтвортой байдлыг хангах, аж үйлдвэрийн технологи, инновацийг хөгжүүлэхээр тусгасан байна.**

- Улаанбаатар, Налайх, Эрдэнэт, Дарханд бизнесийн аж үйлдвэрийн парк байгуулах, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг түшиглэн өндөр хүчин чадлын дулааны цахилгаан станц барих болон Японы Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, байгаль орчныг хамгаалах хоёр дахь төсөл”-ийг эхлүүлэх, зарим чөлөөт бүсийг ашиглалтад оруулах ажлыг эрчимжүүлэхээр тусгасан байна.
- Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, дотоодын хэрэгцээг эх орны буудайгаар 100 хувь, төмсөөр 150 хувь, хүнсний ногоогоор 80 хувь хангахаар тооцжээ.
- Дорнод, Дорноговийн газрын тосны зарим талбайн хайгуулын ажлын хугацаа дуусч байгаатай холбогдуулан үйлдвэрлэлийн олборлолтод шилжүүлэх, шинэ төмөр зам тавих, төмөр замыг цахилгаанжуулах техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулан ажлыг эхлүүлэхээр тусгажээ. Чойр-Сайншанд-Замын Үүд чиглэлийн ба Мянганы замын ажлыг үргэлжлүүлж, 267.6 км замыг ашиглалтад оруулахаар төлөвлөсөн байна.
- Зуун мянган айлын орон сууц төслийн хүрээнд бага, дунд орлоготой өрхөд зориулан улсын төсвийн хөрөнгөөр түрээсийн орон сууц барих, түүнчлэн хот, аймгийн төвийн гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах, хөдөө орон нутагт нийтийн теле-төв байгуулан хүн амын интернэтийн хэрэглээг нэмэгдүүлэх, шинээр гэр бүл бологчид, шинэ төрсөн болон нийт хүүхдэд олгож буй мөнгөн тусламжийг хүүхэдтэй гэр бүлд үзүүлэх мөнгөн тэтгэмж болгох, эрүүл мэндийн даатгалын тогтолцоог шинэчлэх, аутсорсингийн мэргэжилтэн бэлтгэх, нийслэлийн гудамж, талбай, олон нийтийн газарт теле камер суурилуулах зэрэг олон төрлийн шинэ зүйл бүтээн байгуулахаар тусгасан байна.

Засгийн газрын тогтоолд өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын (2009.09.23) хуралдаанаар хэлэлцэж, малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, мал сүргийг эдийн засгийн эргэлтэд оруулахын үүднээс Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Ургамлын үр, үрслэг, суулгац, амьтан, түүний үр хөврөл, түүхий мах, дайвар бүтээгдэхүүн болон бичил биетний өсгөөр, эмгэгт материалын дээжийг улсын хилээр нэвтрүүлэх боомтуудын жагсаалт”-ын хоёрдугаар хэсэгт Өмнөговийн Шивээ хүрэн, Гашуун сухайт, Булганы Бага-Илэнх, Сүхбаатарын Бичигт, Ховдын Булган, Говь-Алтайн Бургастай, Баян-Өлгийн Даян боомтыг нэмж зөвшөөрснөөр амьд мал хөлөөр нь гаргах хилийн боомтын тоо 15-д хүрсэн байна.

Ашигт малтмалын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Засгийн газрын (2009.09.23) хуралдаанаар хэлэлцэж, төслийг дэмжиж УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон байна.

Монгол Улсын 2010 оны нэгдсэн төсвийн тухай хуулийн төслийг Сангийн сайд Засгийн газрын (2009.09.23) хуралдаанд оруулахад төсвийн төсөлд Засгийн газрын гишүүдийн саналыг тусгах нь зүйтэй гэж чиглэл өгсний дагуу Засгийн газрын гишүүдтэй (2009.09.28) хийсэн зангиагүй уулзалтын үеэр төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2010 оны төсөв, хөрөнгө оруулалтын дэлгэрэнгүй мэдээллийг танилцуулсан.

Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай Засгийн газрын (2009.09.30) хуралдаанаар хэлэлцэж, Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газар хооронд байгуулсан “Тогтворжилтын зээл”-ийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжиж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Бүгд Найрамдах Энэтхэг Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр Бүгд Найрамдах Энэтхэг Улсаас авах 25.0 сая ам. долларын “Тогтворжилтийн зээл”-ийн хэлэлцээрт хоёр тал 2009 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр Энэтхэгийн нийслэл Дели хотноо гарын үсэг зурж баталгаажуулсан бөгөөд энэхүү 25.0 сая ам.долларын зээлийн хөрөнгийн эх үүсвэрийг төсвийн алдагдлыг бууруулахад зориулан зарцуулахаар тооцсон байна.

Монгол Улсын 2010 оны төсвийн тухай хууль, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2010 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангийн 2010 оны төсвийн тухай хуулийн төслийг Засгийн газрын (2009.09.30) хуралдаанаар хэлэлцэж, эдгээр хуулийн төслийг мөн өдөртөө УИХ-д өргөн барьсан байна:

- Монгол Улсын 2010 оны нэгдсэн төсвийн нийт орлогыг 2.306.0 тэрбум төгрөг (ДНБ-ний 32.2 хувь), зарлагыг 2.664.6 тэрбум төгрөг (ДНБ-ний 37.2 хувь), нэгдсэн төсвийн нийт алдагдлыг 358.6 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 5 хувьтай тэнцэхүйц хэмжээнд байлгахаар төлөвлөсөн байна. Түүнчлэн улсын төсвийн орлогын доод хэмжээг 1,692.4 тэрбум төгрөг (ДНБ-ний 23.6 хувь), зарлагын дээд хэмжээг 2.126.0 тэрбум төгрөг (ДНБ-ний 29.6 хувь), улсын төсвийн нийт

алдагдлыг 433.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 6 хувьтай тэнцэхүйц хэмжээнд байлгахар тооцсон байна. Монгол Улсын Засгийн газар 2010 онд нийт хөрөнгө оруулалтад 452.5 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

- Орон нутгийн төсвийн орлогыг 266.0 тэрбум сая төгрөг, зарлагыг 269.1 тэрбум төгрөг, Монгол Улсыг хөгжүүлэх санд төвлөрүүлэх орлогын доод хэмжээг 243.1 тэрбум төгрөг, зарлагыг 190.4 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын сангийн төсвийн орлогыг 516.4 тэрбум төгрөг, төсвийн зарлагыг 490.9 тэрбум төгрөг байхаар тооцсон байна.
- Монгол Улсын 2010 оны төсвийн төсөлтэй хамт “Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай”, “Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” зэрэг хуулиудын төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
- Төсвийн 2010 оны орлогын төлөвлөгөөнд нэг унци алтны үнийг 900.0 ам.доллар, цэвэр зэсийн үнийг 5185.0 ам.доллар байхаар тооцож, төсвийн алдагдлыг төсөв хоорондын шилжүүлэг, Засгийн газрын бонд болон зээлийн хөрөнгө зэрэг эх үүсвэрээр санхүүжүүлэхээр тусгасан байна. Монгол Улсын 2010 оны төсвийн алдагдлын ерөнхий харьцаа ОУВС-тай хамтран хэрэгжүүлж буй хөтөлбөрийн дагуу хүлээсэн шалгуур үзүүлэлтийг хангаж байна.

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Засгийн газрын (2009.09.30) хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газрын тогтоол гаргасан байна. Энэ тогтоолд “Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай” Засгийн газрын 2009 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 82 дугаар тогтоолын “Засгийн газрын комисс, үндэсний хороо, ажлын хэсэг, тэдгээрийн дарга” гэсэн 20 дугаар хавсралтад “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглах үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх шийдвэр, стандартын зөрчил, давхардал, хийгдлийг судлан шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах Засгийн газрын ажлын хэсэг” дарга нь “Сангийн сайд” гэсэн 51 дэх заалтыг нэмсэн байна.

Хугацаа тогтоох тухай тогтоолын төслийг Засгийн газрын (2009.09.30) хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газрын тогтоол гаргахаар тогтсон байна. Энэ тогтоолд Газрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмал ашиглах ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулах хугацааг 30 жил, сунгалтыг тухай бүр 20 жил байхаар тогтоосон байна. Газрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5-т “Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид энэ хуулийн дагуу газрыг тусгай зориулалт, хугацаа, болзолтойгоор ашиглуулах бөгөөд уг хугацааг Засгийн газар тогтооно.” гэж заасан байна.

Засгийн газрын үнэт цаас арилжаалах тухай Засгийн газрын (2009.09.30) хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газрын тогтоол гаргахаар тогтсон байна. Энэ тогтоолд “Санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай” Улсын Их хурлын 2009 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 22 дугаар тогтоолын 3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газар болон Айвенхоу Майнз Монголиа Инк ХХК-ийн хооронд байгуулах Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний урьдчилгаа төлбөрийг баталгаажуулахад зориулан 287.5 сая хүртэл ам.доллартай тэнцэхүйц хэмжээний Засгийн газрын бондыг үе шаттайгаар гаргах арга хэмжээ авахыг Сангийн сайдад даалгасан байна. Айвенхоу Майнз Монголиа Инк ХХК-иас хөрөнгө оруулалтын гэрээний урьдчилгаа төлбөрт 250.0 сая ам.долларыг 3 үе шаттайгаар буюу хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурагдсанаас хойш 14 хоногийн дотор 100.0 сая ам.долларын төлбөрийг; гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 14 хоногийн дараа 50.0 сая ам.долларын төлбөрийг; ил болон далд уурхайг барихад шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг бүрэн төвлөрүүлснээс хойш 14 хоногийн дараа 100.0 сая ам.долларын төлбөрийг тус гүйцэтгэхээр тохиролцсон байна. Эдгээр урьдчилгаа төлбөрт баталгаа болгон 5 жилийн хугацаатай, жилийн 3 хувийн хүүтэй Монгол Улсын Засгийн газрын үнэт цаасыг хямдруулан худалдан авах хүсэлтийг хөрөнгө оруулагч талаас манайд санал тавьсан байна. Ингэснээр эхний шатны төлбөрт 115.0 сая ам.доллар, хоёр дахь шатны төлбөрт 57.5 сая ам.доллар, сүүлчийн шатны төлбөрт 115.0 сая ам.доллар буюу нийт 287.5 сая ам.долларын үнийн дүн бүхий Засгийн газрын үнэт цаасыг арилжихаар тооцсон байна.

Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хууль, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2009 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын Нийгмийн даатгалын сангийн 2009 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явцын тухай Сангийн сайд Засгийн газрын (2009.09.16) хуралдааны үеэр Засгийн газрын гишүүдэд танилцуулсан байна. Үүнтэй холбогдуулан 2009 оны үлдэж буй хугацаанд эдгээр хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн Сангийн яамны саналыг дэмжсэн байна. Харин Монгол Улсын 2009 оны төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэлийн тооцоо, үндэслэлийг боловсруулж, УИХ-д өргөн барьсан Монгол Улсын 2010 оны нэгдсэн төсвийн төслийн баримт бичгийн танилцуулгад

тодотгон тусгасан байна. Монгол Улсын 2009 оны нэгдсэн төсвийн төлөвлөгөөгөөр нэгдсэн төсвийн орлого 2054.6 тэрбум төгрөг, үүнээс улсын төсвийн орлого 1621.3 тэрбум төгрөг, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн орлого 132.9 тэрбум төгрөг оруулахаар тусгагдсанаас 2009 оны эхний 8 сарын гүйцэтгэл болон хууль эрх зүйн орчны өөрчлөлт, гадаад зах зээлийн нөлөөлөл зэргээс хамаарч Монгол Улсын 2009 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн орлого 109.2 тэрбум төгрөгөөр буурах, харин Монгол Улсыг хөгжүүлэх сангийн төсвийн орлого 40.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэх тооцоо гарсан байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцэл 2009 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр 334.5 тэрбум төгрөгийн алдагдалтай, 2009 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 273.1 тэрбум төгрөгийн алдагдалтай гарахаар байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ 2009 оны урьдчилсан гүйцэтгэлээр 95.1 хувьтай гарахаар байна.

Төсвийн хүрээний 2010 оны мэдэгдлийн зорилтод нийцүүлэн Монгол Улсын 2010 оны төсвийн зарлагын төслийг боловсруулахад дараахь зарчмыг баримталсан байна:

- **Олон улсын валютын сантай тохиролцсон хямралыг даван туулах хөтөлбөр, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Япон улстай төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зээлийн бодлогын баримт бичигт тохиролцсон арга хэмжээг хэрэгжүүлэхээр тооцлоо;**
- **Хөтөлбөрт суурилсан байх, төсвийн байгууллагын орон тоог нэмэгдүүлэхгүй байх, төсвийн зарлагын хязгаараас хэтрүүлэхгүй байх, шинээр нэмэгдүүлэх хөтөлбөр, арга хэмжээг ач холбогдлоор эрэмблэн тогтоох, төсөв хэмнэлттэй, үр ашигтай байх, төсвийн байгууллагын өөрийн орлого, төсвийн зарлагыг санхүүжүүлэх бусад эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлийг тусгалаа;**
- **Төсвийн урсгал зардлын 55.3 хувийг боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарт, 14.9 хувийг батлан хамгаалах, нийгмийн хэв журмыг хангах салбарт, 7.3 хувийг нийтийн ерөнхий үйлчилгээнд, 2.6 хувийг хөдөө аж ахуйн салбарт, 7.9 хувийг төсөв, санхүүгийн үйлчилгээнд, 11.9 хувийг бусад салбарт зарцуулахаар тусгалаа;**
- **Ирэх 2010 онд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд нийт 452.5 тэрбум төгрөг төлөвлөснөөс улсын төсвийн хөрөнгөөр 358.6 тэрбум төгрөг, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 93.9 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр тусгалаа. Нийт хөрөнгө оруулалтаас барилга угсралтын ажилд 400.3 тэрбум төгрөг (үүнээс: урьд оноос шилжиж ирсэн барилгын ажилд 254.4 тэрбум төгрөг, шинээр эхлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээнд 145.9 тэрбум төгрөг), их засварын ажилд 20.5 тэрбум төгрөг, тоног төхөөрөмж худалдан авахад 31.7 тэрбум төгрөг зарцуулахаар тооцсон байна.**
- Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн 45 хувийг дэд бүтцийн салбарт, 28 хувийг нийгмийн салбарт, 6 хувийг хөдөө аж ахуй, байгаль орчны салбарт, 5.8 хувийг улсын төсвөөс аймаг, нийслэл, орон нутагт хэрэгжүүлэх шууд хөрөнгө оруулалтад, 4.3 хувийг батлан хамгаалах, хууль хяналтын байгууллагад, 4.6 хувийг Монгол Улсын Их Хурлын болон Монгол Улсын Ерөнхий сайд, Тэргүүн Шадар сайд, Шадар сайд нарын эрхлэх асуудлын хүрээний үйл ажиллагааны хөрөнгө оруулалтад зарцуулахаар тооцсон байна.
- Орон нутгийн 2010 оны төсвийн төсөлд улсын төсвөөс орон нутгийн төсөвт 10 аймагт 15.0 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх, улмаар улсын төсөвт орон нутгийн орлогоос нийт 124.8 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр тооцсон болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2009 оны 8 дугаар сарын гүйцэтгэлийн мэдээг нэгтгэн гаргаж, дүнг яамны удирдлага болон олон нийтэд мэдээлэх арга хэмжээ авлаа:

- **Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2009 оны 8 дугаар сарын гүйцэтгэлээр 1137.9 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөөг 23.5 тэрбум төгрөгөөр буюу 2.0 хувиар дутуу биелэгдэж, улмаар 2008 оны мөн үеийнхээс 267.2 тэрбум төгрөгөөр буюу 23.5 хувиар буурсан байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогыг эх үүсвэрээр нь задлан үзвэл татварын орлогоор 80.5 хувийг, татварын бус орлогоор 18.2 хувийг, тусламжийн орлогоор 1.1 хувийг, хөрөнгийн орлогоор 0.2 хувийг бүрдүүлсэн байна.**
- **Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлага 2009 оны 8 дугаар сарын батлагдсан төлөвлөгөөгөөр 1726.3 тэрбум төгрөг (үүнээс: улсын төсвийн зарлага 1318.2 тэрбум төгрөг) зарцуулахаас гүйцэтгэлээр 1472.6 тэрбум төгрөг (улсын төсвийн зарлага 1149.9 тэрбум төгрөг)-т хүрч, төлөвлөсөн нэгдсэн төсвийн зарлагын 85.3 хувийг (улсын төсвийн зарлагын 87.2 хувийг) санхүүжүүлсэн бөгөөд өнгөрсөн 2008 оны мөн үеийнхээс нэгдсэн төсвийн зарлага санхүүжилт 71.0 тэрбум төгрөгөөр буюу 5.1 хувиар өссөн (харин улсын төсвийн зарлага 2008 оны мөн үеийнхээс 76.1 тэрбум төгрөгөөр буюу 7.1 хувиар өссөн) байна.**

- Монгол Улсын төсвөөс 2009 оны 8 дугаар сарын гүйцэтгэлээр цалин, тэтгэвэр, тэтгэмжийг бүрэн олгосон бөгөөд халамжийн сангаас хүүхдийн мөнгөний хөтөлбөрт 27.8 тэрбум төгрөг, шинээр төрсөн хүүхдийн мөнгөн тусламжид 4.3 тэрбум төгрөг, шинэ гэр бүлд олгох мөнгөн тусламжид 10.1 тэрбум төгрөг, жирэмсэн ба нярай эхчүүдийн тэтгэмжид 10.4 тэрбум төгрөг, алдарт эхийн одонтой эхчүүдийн тэтгэмжид 8.9 тэрбум төгрөг, алдар цолтой ахмадын нэмэгдэл, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлтөд 4.5 тэрбум төгрөг, ахмад дайчдын орон сууцны дэмжлэгт 3.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна. Улсын нэгдсэн төсвийн урсгал зардлын 13.6 хувийг буюу 155.2 тэрбум төгрөгийг нийгмийн халамжийн сангийн зардалд, 36.7 хувийг буюу 411.8 тэрбум төгрөгийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд, өөрөөр хэлбэл, нийт урсгал зардлын 50.3 хувийг буюу 564.0 тэрбум төгрөгийг цалин, тэтгэвэр, тэтгэмжид зарцууллаа.
- Орон нутгийн төсвийн орлого 2009 оны 8 дугаар сарын гүйцэтгэлээр 165.2 тэрбум төгрөгт хүрч, төсвийн орлогын төлөвлөгөөг 0.2 хувиар буюу 0.3 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орон нутгийн төсвийн зарлага 154.1 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн нийт зардлын 92.5 хувийг санхүүжүүлсэн байна. Улсын төсөвт орон нутгаас 61,206.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 59,671.3 сая төгрөг (Орхон аймаг орлогын төлөвлөгөөг 2224.1 сая төгрөгөөр давуулан биелүүлж)-ийг төвлөрүүлж, харин улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг орон нутаг 1535.0 сая төгрөгөөр буюу Хэнтий (130.0), Дархан-Уул (249.6), Өмнөговь (700.0), Сэлэнгэ (936.5), Төв (1443.1) аймаг орлогын төлөвлөгөөг тус тус тасалдуулсан байна. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгт 11,179.3 сая төгрөгийг бүрэн олгосон байна.
- Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 8 дугаар сарын орлогод алтны үнийн өсөлтийн албан татвараар 62.5 тэрбум төгрөг төвлөрсөн (төлөвлөгөө 24.5 тэрбум төгрөгөөр давж биелсэн) бөгөөд Монгол Улсыг хөгжүүлэх сангийн зардалд 2009 оны 8 дугаар сарын гүйцэтгэлээр төлөвлөсөн зардлын 62.1 хувийг буюу 129.3 тэрбум төгрөгийг зарцуулжээ.
- Нийгмийн даатгалын сангийн 8 дугаар сарын орлого 304.2 тэрбум төгрөгт хүрч 10.3 тэрбум төгрөгөөр буюу 3.5 хувиар орлогын төлөвлөгөө давж биелсэн байна. Нийгмийн даатгалын санд улсын төсвөөс олгох 107.8 тэрбум төгрөгийн татаасын санхүүжилтийг бүрэн олгож, Нийгмийн даатгалын сангийн зардалд 2009 оны 8 дугаар сарын гүйцэтгэлээр төлөвлөсөн зардлын 99.7 хувийг буюу 288.1 тэрбум төгрөгийг зарцуулжээ.
- Монгол Улсын нэгдсэн төсвийн (өссөн дүнгээр) 2009 оны 8 дугаар сарын гүйцэтгэлээр урсгал тэнцэл 1.3 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 334.5 тэрбум төгрөгийн алдагдалтай (үүнээс: улсын төсвийн урсгал тэнцэл 138.3 тэрбум төгрөгийн, нийт тэнцэл 296.5 тэрбум төгрөгийн алдагдалтай) гарсан байна. Энэхүү алдагдлыг Засгийн газрын бондын арилжаагаар 60.0 тэрбум төгрөгийн, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн эрсдлийн хэсгээс 163.0 тэрбум төгрөгийн, олон улсын байгууллага, хандивлагч улс орнуудаас 164.2 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.
- Улсын төсөвт байгууллагын төсвийн зарлагын 2009 оны 8 дугаар сарын гүйцэтгэлийн мэдээг төсвийн ерөнхийлөн захирагч нараар нэгтгэн гаргаж мэдээлэв. Улс, орон нутгийн төсөвтэй харилцагч төсөвт байгууллагуудын 2009 оны 8 дугаар сарын гүйцэтгэлээр өглөг, авлагын мэдээг батлагдсан маягтын дагуу нэгтгэн гаргаж, ОУВС-д хүргүүллээ. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2009 оны 8 дугаар сарын гүйцэтгэлээр (2009 оны 9 дүгээр сарын 1-ний үлдэгдэл) төсөвт байгууллагын төсвийн нийт авлага 6.5 тэрбум төгрөгт, төсвийн нийт өглөг 10.3 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Батлагдсан төсвийн хуваарийн дагуу улс, орон нутгийн төсөвт байгууллагын 2009 оны 9 дүгээр сарын төсвийн урсгал зардлын эрхийг хянаж, **2009 оны эхний есөн** сарын урсгал зардалд (өссөн дүнгээр) **942.6** тэрбум төгрөг (тухайн сард **89.0** тэрбум төгрөг)-ийн санхүүжилт олголоо.

Засгийн газрын нөөц сан, улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн хураангуй ба дэлгэрэнгүй тайланг нэгтгэн гаргаж, дүнг долоо хоног тутам удирдлагад тайлагнаж байна:

- Засгийн газрын шийдвэрийн дагуу 2009 оны эхний 9 сард Засгийн газрын нөөц сангаас 10,959.1 сая төгрөг (тухайн сард 1,369.5 сая төгрөг)-ийг зарцуулсан байна. Түүнчлэн 2009 оны эхний 9 сард санхүүгийн дэмжлэгээр орон нутагт 11,858.5 сая төгрөг (тухайн сард 679.2 сая төгрөг)-ийг хуваарилсан байна.
- Монгол Улсыг хөгжүүлэх сангаас 2009 оны эхний 9 сард 0-18 насны хүүхдийн мөнгөн тэтгэмжид 62.6 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 78.8 тэрбум төгрөг, улсын

төсвийн алдагдлыг нөхөх зардалд 171.8 тэрбум төгрөг, улсын нөөц бүрдүүлэлтийн ашиглалтын зардалд 3.8 тэрбум төгрөг (нийт 317.0 тэрбум төгрөг)-ийг санхүүжүүлсэн байна.

- Батлагдсан хуваарийн дагуу улсын төсвөөс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 2009 оны эхний 9 сард 138,530.5 сая төгрөг (тухайн сард 30,074.8 сая төгрөг)-ийн, Монгол Улсыг хөгжүүлэх сангаас хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 2009 оны эхний 9 сард 78,845.2 сая төгрөг (тухайн сард 12,233.7 сая төгрөг), нийтдээ хөрөнгө оруулалтад 2009 оны эхний гурван улиралд 217,375.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.
- Төсвийн ерөнхийлөн захирагч нэг бүрийн болон Монгол банкин дахь төрийн сангийн нэгдсэн данс, Хадгаламжийн банкин дахь кассын дансны өдөр тутмын орлого, зарлагын гүйлгээний мэдээг нэгтгэн гаргаж, дүнг удирдлагад танилцуулж байна. Тайлант 2009 оны 9 дугаар сарын 30-ны байдлаар Монгол банкин дахь төрийн сангийн нэгдсэн дансны үлдэгдэл (өмнөх сараас 35.8 тэрбум төгрөгөөр өсөж) 81.7 тэрбум төгрөг, Монгол банкин дахь валютын харилцах дансны үлдэгдэл (өмнөх сараас 103.1 тэрбум төгрөгөөр буурч) 69.4 тэрбум төгрөг, Хадгаламж банкин дахь кассын дансны үлдэгдэл 80.2 сая төгрөг, Санхүүгийн хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэл 20.1 тэрбум төгрөг, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн дансны үлдэгдэл (өмнөх сараас 10.9 тэрбум төгрөгөөр өсөж) 187.0 тэрбум төгрөг болсон байна. Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор Азийн хөгжлийн банкнаас 40.7 сая ам. долларын санхүүжилт ирснээр улсын төсвийн валютын харилцах дансны үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.

Засгийн газар 2009 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр гадаад зээлийн үндсэн төлбөрт 51.4 тэрбум төгрөг (тухайн сард 7.6 тэрбум төгрөг), хүүгийн төлбөрт 18.6 тэрбум төгрөг (тухайн сард 3.8 тэрбум төгрөг), нийт **70.0** тэрбум төгрөг төлсөн байна. Арилжааны банкуудаас дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу 2009 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр зээлийн үндсэн төлбөрт 4.6 тэрбум төгрөг (тухайн сард 245.2 сая төгрөг), хүүгийн төлбөрт 5.4 тэрбум төгрөг (тухайн сард 1,819.9 сая төгрөг), нийт **10.0** тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

#### **Эрдэс баялаг, эрчим хүчний талаар:**

Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн чиглэлээр: Засгийн газраас Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээг байгуулахтай холбогдсон бүхий л ажлыг зохион байгуулж, гэрээ байгуулах нөхцөлийг бүрдүүлсэн.

**Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр батлах тухай** Засгийн газрын 2009.09.30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газрын тогтоол гаргав.

БНХАУ-ын Үндэсний хөгжил шинэтгэлийн хорооны төлөөлөгчдийг хүлээн авч Монгол, Хятадын Засгийн газар хоорондын эрдэс баялаг, эрчим хүчний салбарт хамтран ажиллах хэлэлцээрийг эцэслэн тохиролцож Засгийн газрын 2009.09.23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2009 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 236 дугаар тушаалаар “Си Эм Кэй Ай” ХХК-ийн Хэнтий аймгийн Дархан сумын нутагт орших Бор-Өндөрийн жоншны 16 дугаар хүдрийн биетийн 4153А тоот тусгай зөвшөөрөлтэй талбайд тэсэлгээний ажил хийх, “Пийк Оптим” ХХК-д үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил, үйлчилгээ хийх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатайгаар, 2009 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 261 дүгээр тушаалаар “Тахилт стар” ХХК-д үйлдвэрлэлийн зориулалтаар тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, худалдах, тэсэлгээний ажил, үйлчилгээ хийх, “Жи Эл Ди Ви” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Зүүн Далангийн нүүрсний уурхайн 11281А тоот тусгай зөвшөөрөлтэй талбайд тэсэлгээний ажил хийх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатайгаар тус тус олгож, мөн өдрийн 260 дугаар тушаалаар “Минжит булган гол” ХХК-ийн Төв аймгийн Баян сумын нутагт орших Цагаан толгойн шохойн чулууны уурхайн 806А тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд, “СС Монголиа” ХХК-ийн Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутагт орших Ховд голын гянтболдын уурхайн 1071А тоот тусгай зөвшөөрөлтэй талбайд тэсэлгээний ажил хийх тусгай зөвшөөрлийн хугацааг 3 жилээр сунгав.

Түлш, эрчим хүчний чиглэлээр: Засгийн газрын 2009.09.09-ний өдрийн хуралдаанд эрчим хүчний үнэ тарифын шинэчлэлийн асуудлыг танилцуулж, нарийвчилсан тооцоо, судалгаа хийж дахин танилцуулахаар чиглэл өгсний дагуу ажиллаж байна.

Мөн салбарын санхүүгийн байдал, өр авлагын асуудлыг 2009.09.16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлснээс “Засгийн газрын төрийн өмчит болон төрийн өмчийн

оролцоотой зарим хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 284 дүгээр тогтоол гарав.

Эрчим хүчний салбарын үйлдвэр, компаниудын 2009-2010 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын явц байдалд хяналт тавьж, гарсан хүндрэлийг шуурхай зохицуулалтаар ханган, өвөлжилтийн бэлтгэл ажлын явц байдлын тайланг 2009.09.23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлснээс “Эрчим хүчний салбарын 2009-2010 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах арга хэмжээний тухай” тогтоол гарсан.

Тайширын усан цахилгаан станц, Дөргөний усан цахилгаан станцын эхний ээлжийн агрегатууд ашиглалтад орж байгаатай холбогдуулан цаашид төрийн хамгаалалтад авах тухай асуудлаар яамдаас саналыг авч нэгтгэн Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлэхээр хүргүүлэв.

- **Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2009.09.03-ны өдрийн 238 дугаар тушаалаар Завхан гол, Завхан голоос тэжээгддэг Эрээн, Айраг, Хяргас нуурыг ширгэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор Тайширын усан цахилгаан станцаас гарах усны хэмжээг нэмэгдүүлэх боломжийг судлах, байгаль орчны үнэлгээг газар дээр нь харьцуулалт хийх ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.**
- **Мөн 2009 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 256 дугаар тушаалаар Ховд аймгийн Үенчийн усан цахилгаан станцыг барьж байгуулах үндэслэл, барилга байгууламжийн гүйцэтгэгчийн шалгаруулалт, ажлын гүйцэтгэлийн тайланд үнэлэлт дүгнэлт өгөх ажлын хэсгийг байгуулсан ба ажлын хэсгээс 2 удаагийн уулзалтыг зохион байгуулаад байна.**

Газрын тосны газар, “Монголын Алт” ХХК-ийн хооронд газрын тосны хайгуулын Төхөм-Х (урд) талбайд байгуулах Бүтээгдэхүүн хуваах гэрээний төсөлд яамдаас саналыг авч, гэрээний төслийг үзэглэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулахаар тогтов.

Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэрээс 2008 оны эрчим хүчний үлдэгдэл төлбөр болох 1,6 тэрбум төгрөгийг нүүрсний уурхайнуудын 2009-2010 оны өвлийн бэлтгэлийг хангахад зориулж “тэг үлдэгдэлтэй” дансаар оруулахгүйгээр шууд “Багануур” ХК-нд 900.0 сая.төг, “Шивээ-Овоо” ХК-нд 400.0 сая төг, “Шарын гол” ХК-нд 300.0 сая.төг хуваарилах арга хэмжээг авав.

Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн чиглэлээр: Монгол-Австралийн уул уурхай, эрчим хүчний салбарт хамтран ажиллах ажлын хэсгийн 2 дугаар уулзалтыг Австрали улсын Канберра хотноо зохион байгуулав. Уулзалтаар 2 талын уул уурхай, эрчим хүчний салбарын бодлого, хөрөнгө оруулалтын орчин, нүүрс, зэс, төмөр зэрэг салбаруудын төслүүдийн талаар тус тус харилцан санал солилцов.

“Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль”, “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийг сурталчлах, аюулгүй ажиллагааг хангах зорилгоор тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй харьцаж ажилладаг байгууллага, компаниудын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг ээлжит зөвлөгөөнийг Улаанбаатар хотноо “Бүтээн байгуулах тэсэлгээ” сэдвээр зохион байгуулав.

Түлш, эрчим хүчний чиглэлээр: Эрдэс баялаг, эрчим хүчний сайд, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хооронд байгуулсан “Эрчим хүчний салбарын бодлого, зорилтыг нийслэлд хэрэгжүүлэх талаар 2009-2012 онд хамтран ажиллах санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх хүрээнд нийслэлд ахуйн хэрэгцээний зориулалтаар борлуулагдаж байгаа нүүрсний хангамж, түгээлт, борлуулалтын одоогийн сүлжээг сайжруулах, иргэдийн түлшний зардлыг хэмнэх асуудлыг хэлэлцэх зангиагүй уулзалтыг 2009.09.09-ний өдөр зохион байгуулснаас яамны удирдлагууд, дүүргүүдийн Засаг дарга нар, тохижилт үйлчилгээний компанийн дарга нар, нүүрсний уурхайн удирдлагууд оролцож, санал солилцов.

Улаанбаатар хотод баригдах дулаан, цахилгааны 5 дугаар станцын асуудлаар Азийн хөгжлийн банктай байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу төр-хувийн хэвшлийн түншлэлээр бодлогын, техникийн тусламжийн зөвлөх үйлчилгээтэй холбогдох ажлыг зохион байгуулан жигдрүүлэх, төслийн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих зэрэг арга хэмжээг авч ажиллаж байна.

Шивээ-Овоогийн нүүрсний ордыг түшиглэн байгуулах уурхай-станцын цогцолборын асуудлаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Засгийн газрын ажлын хэсэгт мэргэжлийн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах дэд ажлын хэсгийг сайдын тушаалаар байгуулан ажиллаж байна.

Дөргөний 12МВт-ын усан цахилгаан станц, ОХУ-тай зэрэгцээ ажиллах горимдоо 2009 оны 09 дүгээр сараас орж өдөрт 3-4МВт ачаалалтай ажиллаж байгаа бөгөөд 10 дугаар сард улсын комисст хүлээлгэн өгөхөөр бэлтгэл ажлыг хангуулж байна. Тайширын 11Вт-ын усан цахилгаан станцаас Говь-Алтай аймгийн төвийн тодорхой хэсэг, Жаргалан, Тайшир сумдыг цахилгаан эрчим хүчээр ханган ажиллаж байна.

Яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлыг зохион байгуулж, Алтай-Улиастайн эрчим хүчний системийг найдвартай эх үүсвэрт холбох техник, эдийн засгийн үндэслэл, "Сайншанд салхин парк" төслийн техник, эдийн засгийн үндэслэл, "Гагнуурчдыг мэргэшүүлж эрх олгох дүрэм", "Цахилгаан техникийн байгууламжийн угсралтын норм ба дүрэм", Газрын гүний хөрс, усны дулааныг ашиглан жижиг суурин, багийн төв, байр орон сууцыг дулаанаар хангах судалгаа, техник эдийн засгийн үндэслэлүүдийг тус тус хэлэлцүүлэн шийдвэрлүүлэв.

Улсын төсвийн болон Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр эрдэс баялаг, эрчим хүчний салбарт 2009 онд нийт 25 /Дарханы хотын дулаан хангамжийн системийг хаалттай системд шилжүүлэх төсөл, арга хэмжээ нь 2 удаа нээлттэй тендер зарлагдаж 2 дугаар багцын тендер нь одоо хэрэгжиж байгаа тул 2 төсөл арга хэмжээ гэж тооцсон болно/ төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг хэрэгжүүлэн ажиллахаас:

1. Тендер нь дүгнэгдсэн 20 төсөл, арга хэмжээ /гэрээ нь батлагдсан 20/;
2. Тендер нь хүчингүй болж дахин зарлагдсан 1 төсөл, арга хэмжээ;
3. Тендер нь дүгнэгдэж гэрээ байгуулах шатандаа байгаа 1 төсөл, арга хэмжээ;
4. Тендер нь зарлагдахаар бэлтгэл хангаж байгаа 1 төсөл, арга хэмжээ;
5. Тендер нь зарлагдаагүй 1 төсөл, арга хэмжээ;
6. Захиалчийн эрхийг шилжүүлсэн 1 төсөл, арга хэмжээ байна.

Эрдэс баялаг, эрчим хүчний салбарт 2009 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төлөвлөгөөнд тусгагдсан 16 ажлын 4,0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шилжүүлэв. Хөрөнгө оруулалтын санхүүжилт 40,8 хувьтай байна.

#### **Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын салбарт:**

**Зам, тээврийн чиглэлээр:** Тээврийн хэрэгслийн оношлогоо, хяналт зохицуулалтын албаны зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын Сайдын (2009.09.14) 247 дугаар тушаалаар батлуулав.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, тухайн салбарын мэргэжилтнүүдийг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, зам, тээвэр, барилгын үйлдвэрлэлийн механикжуулалттай холбогдолтой шийдвэрлэх асуудлуудын талаар 2009-2012 онуудад хамтран ажиллахаар Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам, Шинжлэх ухаан, Техникийн Их Сургуулийн Механик инженерийн сургуультай хамтран ажиллах санамж бичгийг (2009.09.14) байгуулав.

Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг оношлогоо явуулах журмын төслийг боловсруулан Автотээврийн газар, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын саналыг авахаар (2009.09.22) хүргүүлэв.

Засгийн газрын хэрэг эрхлэх газраас ирүүлсэн "Журам батлах тухай" тогтоолын төсөл болон "Цацраг идэвхт материал тээвэрлэх журам"-ын төсөл, Цөмийн энергийн газраас ирүүлсэн "Цөмийн болон цацраг идэвхт бодисыг хууль бусаар зөөвөрлөхөөс сэргийлэх асуудлаар хамтран ажиллах тухай Засгийн газрын байгууллагууд хоорондын харилцан ойлголцлын санамж бичгийн төсөл"-д санал боловсруулан (2009.09.22) хүргүүлээ.



Төмөр замын орон нутгийн харилцааны нүүрс тээврийн тарифыг өөрийн өртгийн түвшинд нь хүртэл нэмэгдүүлэх тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулсан ба Засгийн газраас уг асуудлыг Сангийн яамнаас эцэслэн боловсруулж оруулах үүрэг өгсний дагуу холбогдох материалыг Сангийн яаманд (2009.09.21) хүргүүлэв.

*“Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх”* төслийн үнэлгээг эцэслэн хийж, үнэлгээний тайлан, Тавантолгой-Сайншанд чиглэлийн төмөр замын тооцоо, “Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журам”-ын төсөл зэрэг баримт бичгийг боловсруулж байна.

Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” Хувь нийлүүлсэн Нийгэмлэгийн дүрмийн санг 250 сая ам.доллараар хувь тэнцүү нэмэгдүүлэхэд Монголын талд ногдох 125 сая ам.долларыг шийдвэрлэх тухай асуудлыг дахин боловсрууллаа.

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Иргэний нисэхийн осол, зөрчлийг шинжлэн шалгах тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд (2009.09.11) хүргүүлэв.

Олон Улсын Далайн Байгууллагын 5 төрлийн конвенцид нэгдэн орох тухай хуулийн төслүүдийг УИХ-д өргөн мэдүүлэх бэлтгэлийг (2009.09.14) хангав.

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 201 дугаар тушаалаар батлагдсан “Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм”, 188 дугаар тушаалаар батлагдсан “Автотээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам”-ыг нийтээр дагаж мөрдөх шийдвэрийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж Автотээврийн газарт улсын хэмжээнд хэрэгжилтийг хангуулахыг мэдэгдэж 2009.09.04-ний өдөр хүргүүлэв.

БНХАУ-ын хөнгөлттэй зээлээр хэрэгжих Баруун босоо тэнхлэгийн Манхан-Ховд чиглэлийн 90.9 км, Өлгий-Хашаат чиглэлийн 120 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлан хязгаарлагдмал нөхцөлтэйгээр дахин зарлав.

Барилга, орон сууц, нийтийн аж ахуйн чиглэлээр: Барилгын салбар үүсч хөгжсөний 83 жилийн ой, Зураг төслийн байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулав.

Зах зээл дээр бэлэн байгаа 4000 гаруй орон сууцыг урт хугацааны зээлээр төрийн албан хаагчдад олгох санал боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, гарсан шийдвэрийн дагуу 200 орчим тэрбум төгрөгийн Засгийн газрын бонд гарган санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэн шийдвэрлэхээр СЯ, Монголбанктай хамтран ажиллаж байна.

ЭБЭХЯ, БОАЖЯ, ХХААХҮЯ-тай хамтран Дорноговь аймгийн Сайншанд суманд хүнд аж үйлдвэрийн цогцолбор байгуулах анхны төсөөллийг боловсруулан Засгийн газраар хэлэлцүүлсэн. Энэ цогцолборын бүрэлдэхүүнд төмрийн хүдэр, чулуу, шохой гэх мэт барилгын материалын түүхий эдэд түшиглэн төмрийн хүдэр, ган хайлуулах үйлдвэр, цементийн үйлдвэр байгуулахаар төлөвлөөд байна.

“Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д тусгагдсан **“Орон сууц” үндэсний хөтөлбөр** боловсруулах ажлын хэсгийг ЗТБХБ-ын сайдын 2009.08.21-ний өдрийн 226 дугаар тушаалаар байгуулан, хөтөлбөр боловсруулах даалгаврын төслийг боловсруулан ажиллаж байна.

*“Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөр”*-ийн нэгдүгээр үе шатанд баригдах “Орон сууцны ХҮ хороолол”, “Орон сууцны ҮИ хороолол”-ын инженерийн дэд бүтцийг барьж, барилгажилтын ажлыг эрчимжүүлэхээр Засгийн газарт асуудал оруулан хэлэлцүүлж БНХАУ-аас авах 300,0 сая долларын хөнгөлөлттэй зээлээс эдгээр хорооллын инженерийн шугам сүлжээнд 40,0 сая долларыг, орон сууц барих ажилд 60,0 сая долларыг зарцуулахаар шийдвэрлүүлж Засгийн газрын тогтоол гаргуулав.

“Орон сууцны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслүүдэд яамдаас санал авч дахин боловсруулж байна.

Үндэсний хөгжлийн цогц бодлогын орон сууц, усан хангамжийн зорилтуудын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг гаргаж Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороонд хүргүүлэв.

“40000 орон сууц” хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг гаргаж, Засгийн газрын 2009.09.16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.

Засгийн Газрын 182 дугаар тогтоолоор батлагдсан *“Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарыг хувьчлах, өөрчлөн байгуулах чиглэл”*-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийтийн аж ахуйн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөхтэй холбогдсон дүрэм, зөвлөмжийн төслийг боловсруулж ЗТБХБСайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдэж, хамтран батлахаар Төрийн өмчийн хороонд хүргүүлэв. Үүнд:

- Нийтийн аж ахуйн үйлчилгээний хувьцаат компанийн үлгэрчилсэн дүрэм
- Төрийн болон орон нутгийн өмчийн нийтийн аж ахуйн хувьцаат компанийн ажилтнуудад “Хувьцаа эзэмшүүлэх сангаар думжуулан хувьцаа эзэмшүүлэх аргачилсан зөвлөмж
- “Компанийн засаглалын бүрэлдэхүүн хэсгүүд”-ийн талаарх аргачилсан зөвлөмж
- “Компанийн ёс зүйн дүрэм”

ОХУ-ын барилгын салбарын норм, норматив, төсөв, үнэ бүрдэлтийн тогтолцоог судлах, шаардлагатай норм, дүрэм, журмыг худалдаж авах ажлаар ажилтнуудыг явуулах асуудлыг шийдэж ЗТБХБЯ-ны төрийн нарийн бичгийн даргын 2009 оны 223 дугаар тушаал гаргасан.

Хот байгуулалт, газрын харилцааны чиглэлээр: “Монгол улсын хот байгуулалтын салбарын чадавхийг сайжруулах техникийн хамтын ажиллагааны төсөл” болон Япон улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Монгол улсын Засгийн газрын эрх бүхий байгууллагуудын хоорондын санамж бичгийн төсөл дээр 8 дугаар сарын 29, 31, 9 дүгээр сарын 2, 3 –нд санал солилцож, холбогдох саналуудаа тусган 2009 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр санамж бичгийн төсөлд ЗТБХБЯ-ыг төлөөлөн дэд сайд урьдчилсан байдлаар гарын үсэг зурсан.

Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, арга хэмжээнд *“Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүсийн үндсэн дэд бүтцийн асуудлыг Замын-Үүд сумын хэтийн төлөвлөгөөтэй уялдуулан цогц байдлаар шийдвэрлэнэ”* гэж тусгагдсаны дагуу хийж буй ажлуудын талаарх танилцуулга, холбогдох мэдээллийг хавсралтаар гарган Чөлөөт бүсийн зөвлөлийн ажлын албанд 2009.08.31-ний 4/3423 тоот албан бичгээр хүргүүлж ерөнхий төлөвлөгөөний талаарх ажил хэргийн уулзалтыг 2009.09.23-ний өдөр зохион байгуулав.

Азийн хөгжлийн банкнаас олгох хөтөлбөрийн зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжих Нийгмийн салбарыг дэмжих хөтөлбөрийн Хотын хөгжлийн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэсгүүдийн төлөвлөгөөг гарган Сангийн яаманд 2009.09.01-ний 4/3437 тоот албан бичгээр хүргүүлэв.

Зүүн бүсийн хүн амын нутагшилт, суурьшил, төлөвлөлтийн байгууллага (ЕАРОРН)-ын бүс нутгийн 42 дахь удаагийн хурлын үйл ажиллагааг зохион байгуулах арга хэмжээ авч 2009.09.23-наас 25-ны өдрүүдэд зохион байгуулахаар болов.

“Цагааннуур” худалдааны чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөний ажлыг яаралтай дуусгах талаар зураг төслийн гүйцэтгэгч “Идеал групп” ХХК-д 2009.09.21-ний 8/3741 тоот, Сургалт, судалгаа, хөрөнгө оруулалт, барилга захиалагчийн албанд 2009.09.21-ний 8/3740 тоот албан бичиг хүргүүлэв.

БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр Улаанбаатар хотын орон сууцны ҮИ хороолол, МҮОНРТ-ийн ХЭГ-ын орчмын орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээг барьж байгуулах, орон сууцны VII, XIV хорооллын эхний ээлжийн барилгыг барилгажуулахаар болсонтой холбогдуулан эдгээр хорооллуудын техникийн нөхцлийг яаралтай гаргуулах талаар холбогдох байгууллагуудтай тохиролцож энэ сард багтаан шийдвэрлүүлэхээр тохиролцож ажиллаж байна. Үүний үндсэн дээр Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Эрчим хүчний газарт 2009.09.22-ны 4/3759 тоот албан бичиг хүргүүлэв.

“Бүлэг суурингийн төв” болох Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2009.09.16-ны өдөр аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж шийдвэрлэх ажлыг зохион байгуулах талаар аймгийн ИТХ-ын даргад 2009.09.11-ний 5/3594 тоот хүргүүлж 10-р сарын эхээр тус асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхээр боллоо.

2009.09.14-нд сайдын зөвлөлийн хурлаар *“Говийн бүсийн Оюутолгой, Тавантолгой, Цагаан сувагын орд газруудыг түшиглэсэн бүс нутгийн хөгжлийн стратеги, хот байгуулалтын төлөвлөгөө”, “Хот, суурин газарт улаан шугам төсөллөх ба тогтоох заавар”*-ын төслийг хэлэлцүүлэн Засгийн газраар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

“Баруун бүсийн хөгжлийн төсөл”, “Хархорин, Эрдэнэзуу орчмыг аялал, жуулчлалын төв болгон хөгжүүлэх хөтөлбөр”, “Хот, суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар” (УББ-30-201-03)-т нэмэлт өөрчлөлт оруулах төсөл, Хөвсгөл нуур орчмын ерөнхий төлөвлөгөөний төсөл, “Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын хөтөлбөрийн судалгаа” төслийг сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэсэн.

**“Хотууд” үндэсний хөтөлбөрийн** анхны хувилбарыг боловсруулан ажлын хэсэгт танилцуулахаар бэлтгэж байна.

#### **Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн чиглэлээр:**

Монгол банкнаас Дэлхийн банктай хамтран зохион байгуулсан “Мобайл банк” олон улсын зөвлөгөөнөөс гаргасан хөдөлгөөнт банкны үйл ажиллагааг дэмжих эрх зүйн орчинг бүрдүүлэх тухай зөвлөмжийн дагуу Цахим гарын үсгийн тухай хуулийн төсөл боловсруулж, УИХ-аар батлуулах, хөдөлгөөнт банкны үйлчилгээг бодлогын хувьд дэмжихээр болж 2009 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж хүргүүлсэн.

Азийн хөгжлийн банк, Дэлхийн Цахилгаан холбооны байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж эхэлж буй *“Хөдөөгийн мэдээлэл, харилцаа холбооны бодлогын зөвлөгөө, мэдлэгийн солилцоо ба хүний нөөцийн хөгжил”* төслийн дотоодын зөвлөхийн сонгон шалгаруулах шаардлага болон эхний тайлантай танилцаж санал хүргүүлэв.

Мэдээллийн технологийн парктай хамтран “Мэдээллийн технологийн парк-II” төсөл боловсруулж, Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагад уламжлуулахаар Сангийн яаманд хүргүүлэв.

*“Цахим эрүүл мэндийн бодлогын баримт бичиг”*-ийн эхний хувилбарыг бэлэн болгож, 2009.09.18-ны өдөр үндэсний хэмжээний зөвлөлдөх уулзалт зохион байгуулж санал солилцов.

“Аутсорсинг хөгжүүлэх, аутсорсингийн чиглэлээр ажиллах мэргэшлийн ажилтан бэлтгэх” зөвлөх үйлчилгээний тендер, “Програм хангамжийн чанарын стандарт боловсруулах” нээлттэй тендер зарлахаар бэлтгэл ажил хийж байна.

Цахим засаглалын хүрээнд E.GOV.MN төсөл дээр хамтран ажиллах тухай хүсэлтээ Бүгд Найрамдах Солонгос Улсын Үйлдвэрлэлийг дэмжих агентлаг /KIPA/-т хүргүүлэв.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу тус улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Үндэсний дата төв байгуулах төслийг Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран амжилттай хэрэгжүүлж дуусаад Төвийг байнгын

ашиглалтад хүлээн авах ажлын хүрээнд төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын холбогдох хүмүүсээс бүрдсэн техникийн комисс байгуулагдсан.

Жуумла! Монгол өдөрлөгийг 2009.09.29-30-ний өдрүүдэд зохион явуулав. ВЭБ ба Имэйл төслийн хүрээнд төрийн байгууллагуудыг вэб хуудастай, ажилтан бүрийг цахим шуудангийн хаягтай болгох зорилгоор хэрэгжүүлж буй дээрх төслийн хүрээнд 200 гаруй байгууллага вэб хуудастай болсон байна.

Газарзүйн мэдээллийн системийн дэд бүтэц байгуулах төслийн, газарзүйн мэдээллийн системийн дэд бүтэцэд суурилсан хаягжилтын нэгдсэн систем байгуулах төслийн болон эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн системийг шинэчлэх төслийн танилцуулгыг боловсруулав.

Бүртгэлийн нэгдсэн тогтолцоо бий болгох Үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих 6 дэд төсөл */Иргэний ухаалаг үнэмлэх, Цахим архив, Хилийн паспорт хяналтын нэгдсэн сүлжээ байгуулах төсөл, Газар зүйн мэдээллийн систем, хаягжилтын нэгдсэн систем, Үндэсний дата төв/-ийн хүрээнд* Эм Си Эс компани болон Бодь-Электроникс компанийн хийсэн ажлуудтай танилцав.

GPS/GPRS технологид суурилсан хөдөлгөөнт объектын хяналтын бизнесийн GPS-Trace төсөл, "Хилийн паспорт хяналтын нэгдсэн сүлжээ байгуулах", "Цахим архив", "Хуулийн этгээдийн бүртгэл" зэрэг төслийн танилцуулга хийж, төслийн бичиг баримт бэлтгэж байна.

Төрийн байгууллагуудын дунд хэрэгжиж буй мэдээллийн технологитой холбоотой төсөл, хөтөлбөрүүдийн нэгдсэн судалгаа тайлан гаргаж, төрийн байгууллагуудын өндөр хурдны суурь сүлжээ байгуулах төслийг сайжруулан боловсруулахаар талуудтай ярилцаж байна.

Мэдээлэл холбооны үндсэн сүлжээний өргөтгөл, шинэчлэл төслийн тендерийн баримт бичгийг монгол хэлнээс англи руу орчуулав.

Төрийн байгууллагуудын сервер, тоног төхөөрөмжүүд, өгөгдлийн сангуудыг "Үндэсний дата төв"-д нүүлгэн шилжүүлэх төслийг урьдчилсан байдлаар боловсруулав.

#### **Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр:**

УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хороонд Мал эмнэлэг үржлийн чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл бэлтгэж хүргүүлэв.

Салбарын 2010 оны төсвийн төлөвлөгөө, 2010-2012 оны үндсэн чиглэлийн төсөлд санал бэлтгэж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв.

Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөрийг (2009.09.30) Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийг 2009-2010 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Засгийн газрын (2009.09.09) хуралдаанаар хэлэлцүүлэн 280 дугаар тогтоолоор батлууллаа.

"Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль"-ийн төслийг УИХ-ын дэргэдэх ажлын хэсэгт танилцуулахаар бэлтгэлээ.

Бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн төсөл, Хүнсний тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал, "Мал эмнэлэг, үржлийн анхан шатны нэгжийг дэмжих" хөтөлбөрийн төсөл, "Арьс ширний салбарын тогтвортой хөгжлийн хөтөлбөр"-ийн төслийг бэлтгээд байна.

Ургацын төв штабыг Сайдын 215 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Ургац хураалтанд зориулж 6.0 мянган тонн шатахууны хуваарийг хийж, Сайдын 216 дугаараар батлуулж, аж ахуйн нэгжид олгох хэрэгжилтийг зохион байгуулж байна.

ОХУ-ын Ростсельмаш үйлдвэрээс 40 ширхэг НИВА эффект комбайн ирснийг 30 ширхэгийг аж ахуйн нэгжүүдэд, 10-г Сэлэнгэ аймгийн ТӨҮГ-дад хурдан шуурхай хүлээлгэн өгч хураалтанд гаргасан. Энэ сарын 18-20-ны өдрүүдэд орсон цасны улмаас налсан тариа хураах иш өргөгч тоног төхөөрөмжийг 7000 ширхэгийг ОХУ-аас авах талаар хөөцөлдөж, оруулж ирэв. Эдгээрийг аж ахуйн нэгжүүдэд олгож байна.Тендерээр нийлүүлэгдэх JONN DEERE -1076 комбайн 10 ширхэг ирснийг хүлээн авч хувиарлаж хураалтанд гаргалаа.

Улсын хэмжээнд байгаа үтрэм, элеватор будааны агуулахуудын тооллого явуулж нэгдсэн дүнг 2009.09,01-ний өдрийн Сайдын зөвлөлийн хуралд танилцуулав. Тооллогоор тариалангийн бүс нутгийн 8 аймаг, нийслэл, 43 сум, 224 аж ахуйн нэгжийн 200 үтрэм, 118 агуулах, 22 элеватор хамрагдсан байна. Нийт 200 үтрэмд 152.2 га талбай ашиглагдаж байгаагийн 112 үтрэмд хамаарах 88.9 га талбай нь шороон гадаргуутай, 88 үтрэмд хамаарах 32.8 га талбай нь цементэн гадаргуутай байна.Хүнсний буудай хадгалах 333800 тонн багтаамжтай 22 элеватор тоологдсон байна.Элеватор, гурилын үйлдвэрүүдэд хуваарилах буудайн тоо хэмжээг аж ахуйн нэгж бүрээр гаргах тооцоог урьдчилан хийв.

“Өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2009 оны 221 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улсын тусгай хамгаалалттай газар, Улсын хилийн зурвас газар түр хугацаагаар оруулж өвөлжүүлж хаваржуулах өрх, малын судалгааг гаргаж холбогдох газруудад хүргүүлээд байна. Улсын тусгай хамгаалалттай газар 1120.0 мянга, Хилийн зурвас газар 960.0 мянган толгой мал тус тус өвөлжүүлж, хаваржуулах асуудлыг холбогдох яамдуудтай хамтран шийдвэрлэх арга хэмжээ аваад байна. Хадлан тэжээл бэлтгэх ажил 2009.09.28-ны байдлаар өвс 727.3 тн буюу 72.3 хувь, гар тэжээл 23.3 тн буюу 57 хувьтай байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал хадлан 170.0 тн, гар тэжээл 9.0 тонноор илүү байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын уламжлалт “Намрын ногоон өдрүүд-2009” нэгдсэн арга хэмжээг 2009.09.18-24-ний өдрүүдэд Мишээл ЭКСПО төвд амжилттай зохион байгуулав.

- Нэгдсэн арга хэмжээнд нийслэл, хөдөө орон нутгаас нийт 550 гаруй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага оролцож, эх орны үйлдвэрийн хүнсний бүтээгдэхүүн, монгол нутгийн хөрсөнд ургасан төмс, хүнсний ногоо, шилмэл үүлдрийн малаа сурталчилж, иргэд хөдөлмөрчдөд бүтээгдэхүүн үйлчилгээгээ хүргэжээ. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд нийт 23 номинациар шилдэг бүтээгдэхүүн, аж ахуй нэгж, байгууллагыг шалгаруулж өргөмжлөв.
- “Нийслэлийн намрын ногоон өдрүүд-2009” арга хэмжээний хүрээнд Сэлэнгэ, Төв, Орхон, Дархан-Уул аймгийн нийт 20 гаруй сумдын ногоочдыг нийслэлийн Хан-Уул, Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн худалдааны төвүүдэд зохион байгуулагдах үзэсгэлэн худалдаанд оролцуулах хуваарилалтыг хийж Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлэв. “Нийслэлийн намрын ногоон өдрүүд-2009” арга хэмжээ үргэлжилж байна.

ЖДҮ-ийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр улсын төсөвт тусгагдсан 850 сая төгрөг, 30 тэрбум төгрөгийн зохих хувийг аймгуудын ЖДҮ-ийг хөгжүүлэх дэд сангуудад хуваарилан төвлөрүүлэн, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зээл олгох ажлыг эрчимжүүлж байна.Үүнд:

- Орон нутагт хуваарилагдсан эх үүсвэрээс 2009 оны 9 дүгээр сарын байдлаар аймгуудад 1133 төсөлд 13.3 тэрбум төгрөг олгогдож, зээл олголт 83%-тай байна. Улаанбаатар хотод 122 төсөлд 6.2 тэрбум төгрөг олгогдож зээл олголт 64%-тэй байна.
- Бодлогын чанартай томоохон төслийг санхүүжүүлэх эх үүсвэрээс 2009 оны 9 дүгээр сарын байдлаар 10 төсөлд 4.51 тэрбум төгрөг олгогдож, 5.59 тэрбум төгрөгийн 12 төсөл Зээлийн хороогоор шийдвэрлэгдээд байна. 5.51 тэрбум төгрөгийн 16 төсөл судлагдаж, 1.4 тэрбум төгрөгийн 4 төсөл шийдэгдээгүй байна.

#### **Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр:**

Засгийн газраас Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээг байгуулахтай холбогдон “Усны тухай” хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, 23.5, 23.6, 23.7, 24 дүгээр зүйлд тус тус нэмэлт өөрчлөлт оруулж, “Самар экспортлохыг хориглох тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 262 дугаар тушаал гаргав.

2009 оныг байгаль хамгаалагчдыг чадавхижуулах жил болгон зарлаж 21 аймаг, нийслэлд “Байгаль орчны ажилтнуудын орон нутгийн зөвлөлгөөн”-ийг аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгууллаа: Зөвлөлгөөнөөс зөвлөмж, уриалга, төлөвлөгөө гэсэн гурван үндсэн шийдвэр гаргаж байгаль орчны тулгамдсан асуудлуудыг орон нутгийн хэмжээндээ шийдвэрлэх арга замыг тодорхойлж, сургалт зөвлөлгөөний ажиллагаанд оролцсон 2000 шахам хүнд “Байгаль орчны хуулийн эмхэтгэл, дүрэм журмын эмхэтгэл, Байгаль хамгаалагчийн гарын авлага ном тарааж, бүх байгаль хамгаалагчид ажлын цүнх, ажиглалт судалгааны болон ажлын дэвтэр олголоо. Уг зөвлөлгөөн, сургалтын ажлын дүнг нэгтгэж, зөвлөлгөөнөөс гарсан санал шүүмжлэлийн мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөөг 100 асуудалтайгаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 243 тоот тушаалаар батлан хэрэгжүүлж байна.

Байгаль хамгаалагчийн дүрэмт хувцас, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг худалдан авах үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж байна:

1. Өвлийн дүрэмт хувцас/Зхос/	210 хос
2. Зуны дүрэмт хувцас/Зхос/	210 хос
3. Усны гутал	215 хос
4. Борооны цув	210 ш
5. Байршил тогтоогч	85 ш
6. Байгаль хамгаалагчдын цүнх	738 ш
7. Мотоцикл	33 ш

Тусгай зориулалтын ангийн зөвшөөрөл 46, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд зүйл, ойн дагалт баялгийг гадаадад гаргах зөвшөөрөл 6, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд зүйл гадаадад гаргах зөвшөөрөл 2, химийн бодис импортлох, ашиглах, худалдах зөвшөөрөл авахаар 19-ийг олгов.

Улсын Их Хурлаас “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглох” тухай хуулийг 2009 оны 07 дугаар сарын 16-ны өдөр баталсантай холбогдуулан ус ашиглуулах дүгнэлтийг түр зогсоогоод байна.

- 2009 онд байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж буй Увс аймгийн төв Улаангом хот, Дархан – Уул аймгийн Шарынгол сумын төвийн усан хангамжийн зориулалттай усны эрэл, хайгуулын ажил, Өмнөд говийн бүсийн гидрогеологийн нөхцөлд үнэлгээ өгөх сэдэвчилсэн судалгааны ажил зэрэг судалгааны ажлууд амжилттай явагдаж байна.
- Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын нутаг Түлүүгийн буланд, Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг Хөндлөнгийн давааны өвөр Баянцогтын аманд барих Усны хөв цөөрөм байгуулах тендер шалгаруулалтын ажлыг зохион байгуулж, “Тангра-АББ” ХХК, “Аригшан” ХХК-уудыг гүйцэтгэгчээр шалгаруулаад байна.
- Тужийн нарс, Хөгнө тарна, Орхоны хөндийн байгалийн цогцолборт газруудын орчны болон дотоод бүсийн хилийн заагийг тогтоох, Хангайн нурууны байгалийн цогцолборт газрын орчны бүсийн хилийн заагийг шинэчлэх судалгааны ажлыг Сэлэнгэ, Өвөрхангай, Булган, Архангай аймгийн 9 сумын нутагт хийж гүйцэтгэлээ.
- Хөвсгөлийн байгалийн цогцолборт газрын Ханх, Хатгал тосгоны төвийг улсын тусгай хамгаалалтаас гаргах саналын дагуу хил тогтоох судалгааны ажлыг явуулж байна.
- Хан-Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газар, Богдхан уулын дархан цаазат газарт тус тус ажиллаж, газар ашиглалтын байдалд хяналт шалгалт хийлээ.

Аялал жуулчлалын талаар: “Аялал жуулчлал” үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулаад байгаагийн дээр Монгол Улсад аялал жуулчлалын байгууллага байгуулагдсаны 55 жилийн ой тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг тусгай төлөвлөгөөгөөр зохион байгуулж байна.

Израиль улстай хоёр орны хооронд аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурав.

Монгол Улсын гадаад сурталчилгааны эх зохиох, эх бэлтгэх тендерийг явуулж, гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ байгуулав.

#### **Хууль зүйн салбарт:**

Хохирогчид нөхөх олговор олгох тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай, "Хөрөнгө гаргах тухай" Засгийн газрын тогтоолын төслүүд, Хохирогчид нөхөх олговор олгох тухай хуулийг хэрэгжүүлэх журмын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.

Олон улсын далайн байгууллагаас батлан гаргасан конвенци, протоколуудыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл өгсөн.

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн төсөл, Цагдаагийн байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн.

Монгол Улсын уламжлалт мэдлэгийг хамгаалах тухай, Ашигт малтмалын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Татварын ерөнхий хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг хянаж, шийдвэрлүүлсэн.

УИХ-ын гишүүн Д.Оюунхорол, Д.Дондог, Д.Очирбат, З.Энхболд, Д.Энхбат нарын санаачилсан Зохиогчийн эрх ба түүнд хамаарах эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Засгийн газрын санал дүгнэлтийн төслийг бэлтгэн шийдвэрлүүлсэн.

НҮБ-ын "Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн туай Олон Улсын Пактын нэмэлт протокол"-д гарын үсэг зурах тухай, Монгол Улс, Канад улсын хооронд байгуулах "Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай" хэлэлцээрийн албан бус орчуулгын төсөлд санал авах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн заалтыг үндэслэн "Уул уурхайн эцсийн бүтээгдэхүүний жагсаалт батлах тухай", Төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах арга хэмжээний тухай, Төлбөрийн баримтын тухай, Санхүү эдийн засгийн хүндрэлийг даван туулах, төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах арга хэмжээний тухай, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн байдал, цаашид авах зарим арга хэмжээний тухай, Эрчим хүчний салбарын 2009-2010 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай, Хятадын мэргэжилтэй ажиллах хүчнийг Монгол Улсад ажиллуулах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн Газар хооронд байгуулах хэлэлцээрийн төсөлд санал авах тухай зэрэг Засгийн газрын 32 шийдвэрийн төсөлд санал өгөх асуудлыг шийдвэрлэсэн.

"Улсын үзлэг явуулах тухай" Монгол Улсын Ерөнхий сайдын 2009.04.22-ны өдрийн 37 дугаар захирамжаар Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийг удирдан зохион байгуулах төв комиссыг байгуулсан ба уг ажлын хүрээнд төв комиссын ажлын төлөвлөгөө, улсын үзлэгт хамрагдах байгууллагуудын жагсаалт, үзлэг явуулах хуваарь, улын үзлэгт бэлтгэх заавар, дүгнэх үзүүлэлт, аргачлалыг боловсруулан баталж, уг үзлэгийг улс орон даяар зохион байгуулж байна.

Дэлхийн банкны "Захиргааны шийдвэрийг стандартчилах төсөл"-тэй хамтран гаргасан нийтээр дагаж мөрдүүлэхтэй холбоотой материал, гарын авлагыг нийслэл, 21 аймаг, яам, агентлагт хүргүүлэв.

#### **Батлан хамгаалах чиглэлээр:**

Бүс нутгийн цэрэг, улс төрийн байдлын талаар: Дэлхийн санхүүгийн хямралын нөлөөгөөр энэ жил ОХУ-ын дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл тэдний тооцож байснаар 2 хувиар бус, 8,5 хувиар буурах төлөвтэй боллоо. Тус улсын удирдлага эдийн засагтаа бүтцийн өөрчлөлт хийхээр төлөвлөж байна. Кавказын байдлыг тогтворжуулах

бодлогодоо Москва улс төр, цэргийн аргыг хэрэглэж ихээхэн хүчин чармайлт гаргасны дүнд байдлыг хүчээр зохицуулсан боловч эдийн засгийн арга хэрэгслийг орхигдуулснаас сүүлийн үед Умард Кавказад террорист халдлага идэвхжиж байна. Олонх нэгтгэл, ангиудыг байнгын бэлэн байдалтай анги болгох, тэдгээрийг орчин үеийн зэвсэг, байлдааны техникээр хангах, офицерийн орон тоог цомхотгох, цэргийн их, дээд сургуулийг цөөлөх, сургалтын тогтолцоог өөрчлөх зэргээр зэвсэгт хүчнээ мэргэжлийн болгоход чиглэсэн шинэчлэлийг ОХУ эрчимтэй хэрэгжүүлж байна.

Хятадын ШУӨЗО-ны Өрөгич хотод 2009.09.03-нд үндэстний шинжтэй олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал дахин дэгдэв. Тус хотод тариур хэрэглэсэн гэмт хэргийн улмаас 1000 гаруй Хан үндэстэн амь үрэгджээ. Иймээс Хан үндэстнүүд хүчээ нэгтгэж Уйгаруудад хариу бүлэглэн халдах явдал гарсан бөгөөд хууль хяналтын байгууллагынхан Уйгар иргэдийг олноор нь баривчилж, бусад мужийн тусгай хүчний ангиудаас нэмэлт хүч илгээсэн байна. Үүнээс гадна Ардын зэвсэгт цагдаагийн ажилтнууд тусгай ажиллагаа явуулж, томоохон хэмжээний халдлага үйлдэхээр бэлтгэж байсан 6 хүнийг баривчилж, 20 гаруй тэсрэх төхөөрөмж хураажээ. ШУӨЗО-ны Өрөмч хотод байдал тогтворгүй, цаашид даамжрах хандлага ажиглагдаж байна.

Солонгосын хойгийн цөмийн асуудлаарх зургаан талт хэлэлцээг сэргээх талаар зарим дипломат оролдлого хийгдлээ. Хэрэв Умард Солонгос хэлэлцээнд нэгдэж, цөмийн хөтөлбөрөө зогсоовол хориг арга хэмжээг цуцлаж, Пхеньянтай хоёр талын хэлэлцээ хийхэд бэлэн байгаагаа АНУ-ын засаг захиргаа мэдэгдэв. Өмнөд Солонгосын удирдлага цөмийн хөтөлбөрөөс татгалзаж, ердийн зэвсэглэлээ хорогдуулахыг Умард Солонгост уриалаад НҮБ-аар дамжуулан Пхеньянд хүмүүнлэгийн тусламж үзүүлэхийг санал болголоо. Гэвч Умард Солонгосын тал АНУ, Япон хоёр дайсагнасан бодлогоо зогсоовол дипломат харилцааг сэргээж, зургаан талт хэлэлцээнд эргэж нэгдэнэ гэсэн байр сууриа хадгалсан хэвээр байна.

Японы парламентын сонгуульд Ардчилсан нам ялалт байгуулж, Ерөнхий сайд Юкио Хатоямагийн тэргүүлсэн шинэ Засгийн газар ажилдаа орлоо.

Монгол Улс, ОХУ-ын Зэвсэгт хүчний хамтарсан "Дархан-2" хээрийн сургалт, дадлагыг энэ оны 8 дугаар сарын 15-наас 9 дүгээр сарын 10-ны хооронд зохион байгуулж явууллаа. Тус хээрийн сургалт, дадлагад Монгол Улсын Зэвсэгт хүчний 10 ангийн 307 цэргийн алба хаагч, 111 нэгж техник, ОХУ-ын 234 цэргийн алба хаагч, 83 нэгж техник оролцлоо.

Монгол, Энэтхэгийн тусгай хүчний хамтарсан "Нүүдэлчин заан 2009" хээрийн сургалт, дадлагыг Таван толгой дахь Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд амжилттай зохион байгуулж явууллаа. Тус сургалт, дадлагад оролцсон хоёр орны тусгай хүчний цэргийн алба хаагчид мэдлэг туршлагаа хуваалцаж, бие биенээсээ харилцан суралцаж, цэргийн хамтын ажиллагааг бэхжүүлэхэд зохих хувь нэмрээ оруулж, тавигдсан зорилгоо бүрэн дүүрэн биелүүллээ.

Афганистанд үүрэг гүйцэтгэх цэргийн багийн болон сургалтын хөдөлгөөнт багийн ажиллагааны өмнөх сургалтыг Таван толгой дахь Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд зохион байгуулж, бэлтгэлийг нь бүрэн хангууллаа.

#### **Гадаад харилцааны чиглэлээр:**

Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 9 дүгээр сарын 13-16-нд Энэтхэг Улсад төрийн айлчлал хийв: Айлчлалын үеэр Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газар хооронд Тогтворжуулалтын зээлийн Хэлэлцээр, Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах салбар дахь хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Цөмийн энергийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын Атомын энергийн газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг, Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, БНЭУ-ын Статистик, хөтөлбөрийн хэрэгжүүлэлтийн яам хооронд Статистикийн асуудлаар хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын Санамж бичиг, Монгол Улсын Эрүүл мэндийн яам, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Эрүүл мэнд, гэр бүл хамгааллын яам хооронд Эрүүл мэнд, Эрүүл мэндийн шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах тухай Хэлэлцээр, Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газар хооронд соёлын салбарт 2009-2012 онд хамтран ажиллах тухай Хөтөлбөрт гарын үсэг зурав.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 64 дүгээр чуулганы үеэр Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж БНСУ-ын Ерөнхийлөгч Ли Мен Баг, Японы Ерөнхий сайд Хатояма Юкио, Сингапурын Гадаад хэргийн



сайд Жеорж Ео-тай, Гадаад харилцааны дэд сайд Б.Болор Австралийн Гадаад хэргийн сайд Стефен Смит-тай хоёр талын уулзалт хийв.

ОХУ-ын Холбооны Хурлын Холбооны Зөвлөлийн дарга С.М.Миронов Монгол Улсад 2009.09.5-7-нд ажлын айлчлал хийв. **УИХ-ын дарга Д.Дэмбэрэл С.М.Мироновыг хүлээн авч уулзан зоог барив. С.М.Миронов Г.К.Жуковын хөшөөнд цэцэг өргөж, Дундговь аймагт зочлов.**

Монгол Улсын Ерөнхий сайд С.Баярын Австрали Улсад хийх айлчлалыг манай тал хойшлуулахаар шийдвэрлэж, Австралийн талд Канберра болон Сөүл дэх ЭСЯ-аар дамжуулан мэдэгдэв.

АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд М. Минтоныг эх орондоо бүрмөсөн буцах гэж байгаатай нь холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга нар хүлээн авч уулзав. **Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд М.Минтоныг “Найрамдал” медалиар шагнасныг Гадаад харилцааны сайд 2009.09.04-ний өдөр ГХЯ-нд гардуулав.**

БНПУ-ын Эдийн засгийн дэд сайд М.Королец 2009.09.15-ны өдөр Монгол Улсад айлчилж, энэ хүрээнд ГХЯ, ЗТБХБЯ, СЯ болон ЭБЭХЯ-нд тус тус уулзалт хийв. **ГХ-ны дэд сайд Б.Болор, ТНБД Д.Цогтбаатар нартай хийсэн уулзалтын үеэр Монгол, Польшийн худалдааны хэмжээг нэмэгдүүлэх, хоёр улсын Засгийн газар хооронд худалдаа, эдийн засгийн хамтарсан хороо байгуулах, Монгол Улсыг польшийн хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд хамруулах боломж зэргийн талаар хоёр тал ярилцав.**

БНХАУ-аас ажилчин оруулж ирж хөдөлмөр эрхлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийн талаарх хэлэлцээг БНХАУ-ын Худалдааны яамны төлөөлөгчтэй 2009.09.17-18-нд НХХЯ дээр хийв. **Хэлэлцээний үр дүнд хэлэлцээрийн төслийг англи хэл дээр хятадын талтай эцэслэн тохирч үзэглэв.**

ОХУ-ын Ерөнхийлөгчийн энэ оны 8 дугаар сард Монгол Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр байгуулсан “Дорнод-Уран” хязгаарлагдмал хариуцлагатай хамтарсан компани байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр”-ийн эх бичвэрийг албан бичгээр Цөмийн Энергийн газарт хүргүүлэв.

Халх голын ялалтын 70 жилийн ойг угтаж, Халхын голд амь үрэгдсэн Зөвлөлтийн цэргийн дайчдын хөшөө, дурсгалын зүйлсийг хүлээн авах монгол, оросын ажлын хэсгийн баримт бичгүүдийг архивын нэгж болгон ГХЯ-ны Төв архивт шилжүүлэв.

Япон Улсын Засгийн газрын Хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээнд 2011 оны ерөнхий буцалтгүй тусламж, 2010 оны техник хамтын ажиллагаа, хөнгөлөлттэй зээл, хөгжлийн судалгаа болон соёлын буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлэхээр нийт 30 төслийн саналыг Японы ЭСЯ-нд ноотоор уламжлав.

Вьетнамаас ирүүлсэн буцалтгүй тусламжийн эхний ээлжийн 300 тонн цагааны будаанаас Монголд байхгүй 4 төрлийн хортон шавьж илэрсэнтэй холбогдуулж Сангийн яам, Мэргэжлийн хяналтын газартай асуудлыг зохицуулах боломжийн талаар санал солилцов. **Мэргэжлийн хяналтын газар дотоодын хууль тогтоомжоо баримталж тусламжийн барааг буцаахаас өөр боломж байхгүй гэж мэдэгдсэн тул Сангийн яамны Зээл тусламжийн нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Хүрэнбаатар БНСУ-ын Сангийн яамны Олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн дарга Нгуен Тхи Тхань Хуен-д үүссэн нөхцөл байдлыг тайлбарласан захидал илгээж тусламжийн цагаан будааг буцаах саналыг тавив. Тус асуудлаар Азийн газрын захирал Б.Ганболд Вьетнамын Элчин сайд Нгуен Хью Тхань-ийг хүсэлтээр нь хүлээж авч уулзав.**

ГХЯ-ны Азийн газрын захирал Б.Ганболд БНСУ-ын Элчин сайд Жон Ир-ийг хүлээн авч уулзаж, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцож, Монгол, БНСУ-ын Дунд хугацааны хамтын ажиллагааны хөтөлбөрийн манай талын хариу төслийг гардуулав.

Мексикийн Нэгдсэн Улсын 200 жилийн ой 2010 онд тохиохтой холбогдуулан зургийн үзэсгэлэнг Улаанбаатар хотноо зохион байгуулах, Мехико хотыг Улаанбаатар хоттой эгч дүү хот болгох, нийслэлийн аль нэгэн сургуулийг Мексикийн нэрэмжит болгох зэрэг асуудлаар Мексикийн талаас тавьсан саналуудыг холбогдох газруудад уламжилж, хариуг Сөүл дэхь ЭСЯ-нд нь илгээв.

Монгол, Чехийн ЗГХХК-ын ээлжит 2 дугаар хуралдаан 2009.09.03-нд Улаанбаатарт амжилттай болж, Чехийн Үйлдвэр, худалдааны дэд сайд Ховорка, манай талаас ЗТБХБ-ын сайд Х.Баттулга нар Протоколд гарын үсэг зурав.

Монгол Улс, Европын Холбооны Хамтарсан хорооны 12 дугаар хуралдаан 2009.09.28-29-нд Брюссельд болохтой холбогдуулан бэлтгэл ажлыг ханган ажиллав.

Монгол Улс, ЕХ-ны хоорондын Түншлэл, хамтын ажиллагааны Хэлэлцээрийн хэлэлцээг эхлүүлэх арга хэмжээг 2009.09.17-нд Улаанбаатарт зохион байгуулав. **Монгол Улсын Шадар сайд М.Энхболд Европын Холбооны төлөөлөгчдийг хүлээн авч уулзаж, хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.**

2009.09.04-нд Сөүл хотноо болох Азид хамтран ажиллах, итгэлцлийг бэхжүүлэх зөвлөлгөөн (АХАИБЗ)-ий “Эрчим хүчний аюулгүй байдлын асуудлаар хамтран ажиллах нь” сэдэвт мэргэжилтнүүдийн уулзалтад оролцох чиглэлийг Сөүл дэх ЭСЯ-нд өгөв.

ЮНЕСКО-гийн Ерөнхий бага хурлын 35 дугаар чуулганд оролцох төлөөлөгчдийн бүрэлдэхүүний талаарх саналыг ЮНЕСКО-гийн Үндэсний Комисст хүргүүлэв.

2009.09.16-19-ний өдөр Ази, Европын сан АСЕФ-ын Гүйцэтгэх захирлын орлогч Нгуен Квуок Кхан Улаанбаатар хотод ажиллав. Тэрээр ГХЯ-ны ТНБД, ОУБГ-ын Дэд захирал, БСШУЯ, ЮНЕСКО-гийн Үндэсний комисс болон МУИС-ын холбогдох албан тушаалтнуудтай уулзав.

АНУ-тай хэлэлцэж буй “Ил тод байдлын гэрээ”-ний угтвар судалгааны хариуг эцэслэн гаргаж Элчин сайдын яамны албаныханд гардуулав.

Худалдаа, эдийн засгийн харилцааны чиглэлээр: БНХАУ-ын Гирин мужийн Чанчунь хотноо 2009.09.1-4-ний өдрүүдэд болсон Зүүн Хойд Азийн Худалдаа, хөрөнгө оруулалтын 5 дахь удаагийн үзэсгэлэн яармагт Шадар сайд М.Энхболд тэргүүтэй төлөөлөгчид оролцов.

“Шанхай 2010 ЭКСПО” дэлхийн үзэсгэлэнд бэлтгэх ажлын хэсгийн хуралдааныг зохион байгуулав. Хуралдаанаар бэлтгэл ажлын явцын талаар мэдээлэл хийж, ойрын үед хийж гүйцэтгэх ажлын талаар холбогдох байгууллагуудад чиглэл өгөв.

ДХБ-тай хамтран “Үйлчилгээний худалдааны Ерөнхий хэлэлцээр”-ийн талаар Үндэсний семинарыг 2009.09.22-24 өдрүүдэд зохион байгуулав.

Монгол-Канадын хооронд байгуулахаар ажиллаж буй “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах” тухай хэлэлцээрийн 3 дугаар үе шатны хэлэлцээг Улаанбаатар хотноо 2009.09.21-22-ны өдрүүдэд зохион байгуулав.

Консулын харилцааны чиглэлээр: Монгол Улс, БНХАУ-ын ГХЯ-ны консулын зөвлөлдөх уулзалтын дүнгээр илтгэх хуудас боловсруулав. Зөвлөлдөх уулзалтын дүнг Сайдын зөвлөлөөр хэлэлцээд гаргах зөвлөмжийн төсөл боловсруулж албан ёсны хэлэлцээний үеэр манай талаас тавьсан асуудлыг Санамж бичиг болгон Хятадын ЭСЯ-нд ноотоор хүргүүлэв.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад харилцааны сайд нарын хамтарсан 2009 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 173/75 тушаалаар “Чөлөөт бүсэд виз олгох хялбарчилсан журам”-ыг батлуулж, ЗГХЭГ-ын дэргэдэх Чөлөөт бүсийн ажлын алба болон “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн захиргаанд хүргүүлэв.

Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн анхдугаар хурлыг зохион байгуулав. Тус сангаас тусламж олгох 4 иргэний асуудлыг Сангийн зөвлөлийн хурлаар шийдвэрлэв.

Монгол Улсаас Хонгконгийн ЗЗОБ-д суух Өргөмжит консулаар Чен Хоичи, Энэтхэг Улсын Бангалор хотод суух Өргөмжит консулаар С.Васудеван нарыг томилох асуудлыг сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэв.

Монгол Улсаас Энэтхэг Улсын Бангалор хотод суух Өргөмжит консулаар С.Васудеванийг томилоход зөвшөөрөл хүссэн к/09-1258 дугаарт ноотыг Дели дэх ЭСЯ-нд хүргүүлэв.

Норвегийн Вант Улсаас Монгол Улсад суух Өргөмжит консулаар томилогдсон Л.Сарангэрэлд ГХЯ-наас олгосон Экзекватурыг бэлтгэн Бээжинд суугаа Норвегийн ЭСЯ-нд хүргүүлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс БНХор.У, БНПУ, БНИта.У-ын Ерөнхийлөгч нарт талархлын захидлууд, Холбооны Бүгд Найрамдах Бразил, Катар Улсын Тусгаар тогтнолын өдрийг тохиолдуулан, Киргиз, Молдова, Украин, Армян, Узбек, Беларус,Тажик, Киргизийн үндэсний баярыг тохиолдуулан баярын цахилгаан утас, БНАСАУ байгуулагдсаны 61 жилийн ойг тохиолдуулан БНАСАУ-ын Батлан хамгаалах хорооны дарга Ким Жөн Ир-т баяр хүргэж илгээлт илгээв. Мөн Словак Улсын Үндэсний баярыг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Гадаад харилцааны сайд нараас илгээх баярын мэндчилгээний төслийг боловсруулж, албажуулахаар холбогдох газарт хүргүүлэв.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар